

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-51

1.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	6-33
2.Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдсан ажлын хэсгийн явц, үр дүнгийн талаарх танилцуулга	33-37
3.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	37-50

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
12 дугаар сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 31 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 35 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: П.Батчимэг, Ш.Бямбасүрэн, М.Мандхай, Э.Одбаяр, Б.Пунсалмаа, Б.Уянга;

Эмнэлгийн чөлөөтэй; Ж.Ганбаатар;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, Х.Булгантуяа, Б.Жавхлан, О.Цогтгэрэл.

Нэг.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, Т.Билэг-Өрнөх, М.Мандхай нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, С.Цэнгүүн, Ч.Анар, Г.Очирбат, Ч.Лодойсамбуу, Л.Энх-Амгалан, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ч.Лодойсамбуу, Л.Энх-Амгалан, П.Сайнзориг, Р.Сэддорж, Ж.Энхбаяр нар үг хэлэв.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Жаргалан ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Байнгын хорооны дарга Р.Сэддорж ажлын 5 өдрийн завсарлага өгөв./14:11/

Хоёр.Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдсан ажлын хэсгийн явц, үр дүнгийн талаарх танилцуулга

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, Т.Билэг-Өрнөх, М.Мандхай нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Ажлын хэсгийн үйл ажиллагааг дуусгавар болгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Д.Үүрийнтуяа нар үг хэлэв.

Р.Сэддорж: “Ажлын хэсгийн үйл ажиллагааг дуусгавар болгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, мөн газрын ахлах зөвлөх С.Энхцэцэг, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, Т.Билэг-Өрнөх, М.Мандхай нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Г.Тэмүүлэн, Байнгын хорооны дарга Р.Сэддорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд 14 цаг 41 минутаас 14 цаг 51 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Д.Үүрийнтуяа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалт “өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг тогтворжуулах, иргэдийн бодит орлогыг хамгаалах чиглэлээр мөнгөний бодлого, мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 10
Бүгд: 18
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үйл ажиллагааг биржийн арилжаанаас нь салгаж, бие даасан байдлаар зохицуулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Дээрх санал дэмжигдсэнтэй холбогдуулан, Төслийн 1.2 дугаар заалт “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлэхүйц тээвэртэй холбоотой аливаа нэмэлт зохицуулалт, шийдвэр гаргахгүй байх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 1 дэх хэсгийг “Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалах, үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Занданшатар/-т даалгасугай. Үүнд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг “хилийн боомтууд, гаалийн үйл ажиллагаа болон тээвэр логистикийн саатлыг багасгаж, импортын барааны үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэхийн тулд боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, дэд бүтцийг шинэчлэх, гаалийн бүрдүүлэлтийг бүрэн цахимжуулах, хяналтыг нэгдмэл

удирдлагын тогтолцоонд оруулах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 10

Бүгд: 18

44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 1.5 дахь заалтын “барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” гэснийг “импорт орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 10

Бүгд: 18

44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 8 дугаар хэсгийн 8.а.төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор төсвийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг нягтлах, 8.б.бүтээмжид суурилсан төрийн албан хаагчийн цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох гэсэн 2 заалтыг нэгтгэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 10

Бүгд: 18

44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 8.в дэх заалтын “үр өгөөж бага, олон нийтийн арга хэмжээ, сурталчилгаа, гадаад томилолт, автомашин, тавилга худалдан авах зэрэг урсгал зардлыг үе шаттайгаар бодитой бууруулах” гэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай давхцаж байгаа тул хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 14

Бүгд: 18

22.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 2.1 дэх заалтын “макро зохистой бодлого” гэснийг “макро эдийн засгийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 12

Бүгд: 18

33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 8.2.2 дахь заалтын “гадаадын банкны салбаруудыг” гэснийг “гадаадын банкнуудын салбарыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн “Энэхүү тогтоолын хэрэгжилтийн явц, биелэлтийг” гэснийг “Энэхүү тогтоолыг шуурхай хэрэгжүүлж, биелэлтийг заалт бүрээр гарган, Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/, Монголбанк /С.Наранцогт/, Санхүүгийн зохицуулах хороо /Т.Жамбаажамц/, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/, Төсвийн байнгын хороо /Н.Наранбаатар/-т тус тус даалгасугай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Р.Сэддорж: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 05 минут үргэлжилж, 31 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 58.1 хувийн ирцтэйгээр 15 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
12 цаг 35 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд Монгол Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар, Ринчиндоржийн Батболд, Нацагдоржийн Батсүмбэрэл, Пүрэвжавын Ганзориг, Батбаярын Жаргалан, Батжаргалын Заяабал, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Ганзоригийн Лувсанжамц, Бадрахын Найдалаа, Ганбатын Очирбат, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Агваанлуvsангийн Ундраа, Саруулсайханы Цэнгүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Мөнхчулууны Энхцэцэг, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 54,8 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. 2.Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдсан ажлын хэсгийн явц, үр дүнгийн талаарх танилцуулга. 3.Чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 4.Бусад гэсэн 4 асуудал энэ долоо хоногийн тов дараалалд орсон байгаа. Үүнээс бусад гэсэн асуудлын хүрээнд хэлэлцэх асуудлын талаар шийдвэр чиглэл ирээгүй тул өнөөдрийн хэлэлцэх асуудлын дарааллаас хасаж байна.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэх асуудал нэг. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Жадамбын Энхбаяр танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

Ж.Энхбаяр: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүдээ та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгаж байна.

Монгол Улс, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Алсын хараа 2050 хөгжлийн бодлогод олон тулгуурт эдийн засагтай улс болох зорилтын хүрээнд 2030 он гэхэд бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх зорилтыг тавьсан билээ. Мөн Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, бизнес хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, олон тулгуурт эдийн засгийг бэхжүүлэх, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийг дэмжсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгасан болно.

Өнөөдөр Монгол Улсын аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, эдийн засгийг зохицуулахтай холбоотой 200 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа ч эдийн засгийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх, тогтвортой байдлыг хангах талаар нэгдсэн зохицуулалт бүхий хууль батлагдаагүй байна. Олон улсын туршлагаас харахад аж ахуйн үйл ажиллагааны эрх чөлөөг хуульчлан баталгаажуулах, төрийн оролцоог хязгаарлах нь бизнес эрхлэгчид болон хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад эерэг нөлөө үзүүлдэг байна. Мөн төрийн оролцоог бууруулах нь зах зээлийн үр дүнтэй үйл ажиллагааг хангаж, эдийн засгийн тогтвортой байдал, өсөлтийг дэмжих төдийгүй хөрөнгө оруулалт, инновацыг дэмжих таатай орчныг бүрдүүлдэг байна.

Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр Монгол Улс 2025 онд 176 улсаас 76 дугаар байранд эрэмбэлэгдэж, нарийвчилсан дэд үзүүлэлтийн оноогоор өмчийн эрх, төрийн зарчимт байдал, бизнесийн эрх чөлөө, хөрөнгө оруулагчид ээлтэй байдал зэрэг үзүүлэлтээр дунд, бага гэж үнэлэгдлээ. Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбарт төвлөрсөн бүтэцтэй хэвээр байгаа бөгөөд 1990-ээс 2025 оны 2 дугаар улирал хүртэл хугацаанд орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын 74 хувь нь уул уурхайн салбарт ногдож байна. Сүүлийн 10 жилд гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал жилд дунджаар 2,6 тэрбум ам.доллар байгаагийн 2,2 тэрбум ам.долларыг Оюу толгой төсөл дангаараа бүрдүүлсэн боловч хөрөнгө оруулалтын буцаан төлөлтийн нөлөөгөөр цэвэр дүнгээр орж ирж буй хөрөнгө оруулалтын дүн 1 тэрбум ам.доллар хүрэхгүй байна.

Уул уурхайн болон уул уурхайн бус салбарын хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгалын өсөлт буурч байгаа тул эдийн засгийн бүх салбарыг тэлж, төрөлжүүлэх, салбаруудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх зүй ёсны шаардлага үүсэж байна. Иймд хөгжлийн бодлогод туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, бизнес, хөрөнгө оруулалтын орчинд тулгамдаж буй хүндрэлийг шийдвэрлэх зорилгоор Засгийн газраас Баялаг бүтээгчдийг дэмжих багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийг санаачлан боловсруулаад байна.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн зорилго нь иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулж, төрийн оролцоог багасгах, бизнес эрхлэх орчныг сайжруулахад чиглэгдсэн болно. Хуулийн төсөлд эдийн засгийн эрх чөлөөг хангах үндсэн зарчмуудыг тусгаж, төрөөс эдийн засгийн эрх чөлөөг хангахтай холбоотой бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойллоо. Төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс бизнес эрхлэгчийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад сөргөөр нөлөөлөх хориглох үйл ажиллагааг тодорхойлсон болно. Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх механизмыг бий болгож, орон тооны бус эдийн засгийн

бодлогын зөвлөлийн чиг үүрэг болон төрийн бодлогын шийдвэр гаргалтад хувийн хэвшлийн оролцоог хангах зохицуулалтыг тусгалаа.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг дагалдан хөрөнгө оруулалтыг татах, дахин хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, хөрөнгө оруулагчийн хууль ёсны баталгааг хангах зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан. Тус хуульд Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, гомдлыг шуурхай барагдуулах зорилгоор Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн чиг үүргийг тодорхой болгож, хөрөнгө оруулалтын баталгааг хангах хуулийн зохицуулалтыг сайжруулсан болно.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль болон Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд улсын төсвөөс нэмэлт зардал үүсгэх, шинэ бүтэц, орон тоо бий болгох зохицуулалт агуулагдаагүй болно. Тус хууль батлагдсанаар аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн эдийн засгийн эрх чөлөө хангагдаж, төрийн байгууллагын аж ахуйн үйл ажиллагаа дахь оролцоо, сөрөг нөлөөлөл буурч, хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчин бүрдэх болно. Иймд хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД байна уу? Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Саруулын Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга.

Хууль, хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Лодойсамбуу гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

Л.Соронзонболд: Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төсөл ерөнхий санаа агуулгын хувьд дэмжиж байгаа. Энэ дээр энэ аж ахуйн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын давхардлыг арилгана, төрийн байгууллагуудаас мэдээллийг мөн давхардуулж авдаг асуудлуудыг арилгана гэдэг талаар тусгасан гэж ярьж байгаа. Тэгэхээр энийгээ яг бодит амьдрал дээр нэг хэрэгжүүлэх дээр энэ хуулийн төслийг цааш нь энэ сурталчлах, ойлгуулах ухуулах ажлууд аягүй их чухал гэж үзэж байгаа юм.

Сая би жишээлбэл Дорнод аймагт ажиллаад ирлээ. Тэгэхэд шинээр нэг үйлчилгээний төв барьсан хүн гэхэд үйл ажиллагааг нь цагдаагаас очоод л, цагдаагийн байгууллагаас орон нутгийнх нь цагдаа очоод л хязгаарлаж байх жишээтэй иймэрхүү асуудал яригдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө бидний төрийн бодлого нь болохоор илүү хүн бизнес эрхлэх боломжийг нь нээх талаар яриад байдаг. Нөгөө талдаа яг тэр бодит ажлыг амьдрал дээр хэрэгжүүлж байгаа дунд шатны мэргэжилтнүүд маань энэ тал, мэргэжилтнүүд, ажилтнууд маань энэ талын ойлголт харилцан адилгүй байгаад байгаа байх. Тийм учраас энэ дээр ер нь яг энэ хуулийн төсөл дээр яг хэрэгжүүлэх тал дээр ер нь яг ямар байдлаар төлөвлөж тусгаж байгаа вэ гээд 1 дүгээр асуулт байна?

2 дугаарт болохоор энэ Эдийн засгийн бодлогын зөвлөл бол яг энэ хуулийн дагуу байгуулагдаад, Ерөнхий сайдын удирдлага дор ажиллах юм байна. Тэгэхээр энэ Эдийн засгийн бодлогын зөвлөл маань 50 гаруй хүний бүрэлдэхүүнтэй. Энэ бүрэлдэхүүн маань ер нь яах юм бэ, жил болгон солигдож явах юм уу, эсвэл тодорхой хугацааны интервалтайгаар сонгогдоод явах юм уу, энэ дээр ямар байдлаар тусгагдсан бэ гэдэг нэг ийм асуулт байгаад байна.

Дараагаар нь болохоор энэ гадаадын ТӨК-ийн энэ хөрөнгө оруулалт оруулах дээр 33 хувиас дээш тухайн компанийн 33 буюу түүнээс дээш хувь хэрвээ гадаадын төрийн өмчит компани эзэлдэг бол хөрөнгө оруулалтын хяналтыг хийнэ гэдэг ийм асуулт орсон байгаа. Тэгээд бид болохоор одоо стратегийн салбар гээд хэд хэдэн салбарт гадаадын төрийн өмчит компаниуд хөрөнгө оруулах дээр нэлээн хязгаарлалтай байдаг. Энэ асуудал дээр ер нь цаашдаа манай тухайн ялангуяа тэр уул уурхай байгаа, банк байгаа, харилцаа холбоо гээд хэд хэдэн салбар байдаг. Энэ салбарууд дээр өөрчлөлт оруулах талаар ямар бодлого Эдийн засаг, хөгжлийн яамнаас баримталж байгаа вэ?

Р.Сэддорж: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Үнэхээр энэ гол судалгаануудаар энэ төрийн албаны хүнд суртал, зөвшөөрөл дагасан гомдол их өндөр ирээд байгаа юм. Ганц иргэдийн, би олон жишээ хэлж болохоор байна л даа. Жишээ нь Дорноговь аймагт гэхэд нэг үйл ажиллагаа эхэлсэн 20 сар болж байгаа компанид гэхэд л 14 удаагийн шалгалт орон нутгаас очсон байх жишээтэй. Мэргэжлийн хяналтын салбарыг салбарын хяналт болгож яамнуудад өгсөнтэй холбоотойгоор яг энэ давхардсан хяналтын тоо хэтэрсэн. Засгийн газрын гомдол хүлээж авч байгаа 11 11 төв дээр ирж байгаа гомдлын дийлэнх хувь энэтэй холбоотой. Төрийн хяналт шалгалт замбараагүй болж байна, давхардаж байна, чирэгдэл учруулж байна, хүнд суртал учруулж байна. Нөгөө талаас олгож байгаа хуулиас давсан дүрэм журмууд их байна. Мөн энэ зөвшөөрлүүд журмаар олгосон зөвшөөрлүүд, хязгаарлалтууд, дүгнэлт нэрийн доор гарч байгаа энэ хязгаарлалтууд маш их байна гэдэг. Ингээд ер нь цогцоороо Засгийн газар бизнес эрхлэх, эдийн засгийг нэлээн тэлэхийн тулд эдийн засгийнхаа эрх чөлөөг нэлээн хууль, эрх зүйн хувиар баталгаажуулах ёстой гэсэн бодлогын хүрээнд хууль орж ирж байгаа.

Их Хурлаас сая Засагт үүрэг өгчихсөн, энэ хяналтыг цэгцлэх гэдэг үүрэг. Энэ ажлыг мөн Эдийн засаг, хөгжлийн сайд хариуцаад, бид зохион байгуулалтын арга хэмжээг авч байна. 3 сар гэхэд бид Төрийн хяналт шалгалтын хуульд нэмэлт, өөрчлөлт болон шинэ бүтцийг хамт өргөн барих ийм бэлтгэл ажлыг хийж байгаа. Энэ хуулиараа яг ингэнэ гэдэг биш, хуулиар бол энэ хуулийн гол цөм нь ерөөсөө үндсэн суурь зарчмуудыг л тунхаглан зарлаж байгаа манай бизнесийн Үндсэн хууль гэж ойлгож болно. Эдийн засгийн зөвлөл ингээд Ерөнхий сайдын дэргэд байгуулагдаж, Ерөнхий сайд 50-аас доошгүй хувь нь хувийн хэвшил, шинжлэх ухааны байгууллага, холбоодын төлөөллийг дэргэдээ байлгаж, энэ эдийн засагтай холбоотой гомдол чирэгдлийг хурдан түргэн шийдвэрлэх улс төрийн шийдэл гаргах үүднээс ингээд байгуулж өгч байгаа.

Төрийн гадаад хөрөнгө оруулалттай стратегийн салбартай холбоотой энэ зохицуулалтаар нэлээн тодорхой болгож байгаа зүйлүүд байгаа. Ялангуяа гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх зөвшөөрлийг бид нэлээн олон чиглэлээр хязгаарладаг. Стратегийн харилцаа

холбоо, боловсролоос авхуулаад эрчим хүч гээд. Тэгэхээр энэ хяналт шалгалтын асуудлыг нэлээн тодорхой болгож байгаа зүйлүүд энэ хуульд орсон байгаа. Жишээлбэл уул уурхай байна, харилцаа холбоо байна, банк санхүүгийн салбарын гадаадын ТӨК-д хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгохдоо нэлээн өндөр шалгуур босгыг тавьж, дотоод стратегийн зах зээлээ хамгаалсан зохицуулалтад орсон байгаа гэж, болсон.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн.

С.Цэнгүүн: Өглөөний мэнд хүргэе. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа нь Монгол Улсад хамгийн тулгамдаж байгаа асуудал мөн үү гэвэл мөн. Гэхдээ энийг яг хуулийн төслөөр бүрэн шийдвэрлэж чадах дээр би жоохон эргэлзээд байгаа юм. Яагаад гэхээр ер нь бид чинь ингээд Монголд асуудал байхаар нэг Зөвлөл байгуулаад, нэг хэдэн хүн аваачиж хуралдуулаад л энэ асуудал шийдэгдчих юм шигээр ойлгоод байгаа юм л даа. Тэгээд энэ Эдийн засгийн зөвлөл дээр нь болохоороо Засгийн газар ерөнхийдөө ямар хүмүүс орох вэ гэдгээ өөрсдөө шийдэх юм байна. Тэгэхээр чинь энэ 50 хүний бүрэлдэхүүн дотор орж чадсан компанийнх нь ч байдаг юм уу, хувийн хэвшлийнхэн нь эрх ашиг, дээрээс нь тулгамдаж байгаа асуудлуудаа шийдвэрлүүлээд, бусдууд нь орхигдоод яваад байх юм биш үү. Дээрээс нь энэ нь хэр хугацаанд тухайн зөвлөл дээр хүмүүс нь байж байх юм бэ, сонгогддог байх юм уу, сонгогддоггүй байх юм уу гэх мэт олон асуудлыг дагуулж байгаа юм.

Тэгэхээр ер нь зүгээр ийм зөвлөл байгуулаад л, тухайн зөвлөл дээр асуудал шийдэгдэнэ гэхээр чинь нөгөө бүтэц томруулдагтай л адилхан байгаа юм л даа. Төрийн албаны ёс зүйн тухай хуулийг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль гээд бас баталж байсан. Тэгээд тэрэнтэй холбоотойгоор баахан Ёс зүйн дэд хороо гаргасан. Хувь хүний ёс зүй, ёс суртахуунтай холбоотой хуулиар буюу шийдэх хэм хэмжээг зохицуулах боломжгүй зохицуулалтуудыг бид ингээд хуульдаа гаргаж өгчихдөг. Тэгээд дахиад баахан бүтцээ нэмж байдаг нэг ийм сонин тогтолцоо руу ерөнхийдөө яваад байгаа юм. Тэгээд эдийн засгийн эрх чөлөө өөрөө аягүй чухал байдаг. Гэхдээ энэ нь Үндсэн хуулийнхаа дагуу л бид уг нь хангалттай тусгаад өгчихсөн шүү дээ, манай улс чөлөөт эдийн засаг дээр тулгуурласан, хувийн өмчийг хамгаалдаг байна гэдгээ заагаад өгчихсөн. Гэтэл энэ дээр байгаа заалтуудыг нь харахаар надад жоохон угаасаа хэрэгжихгүй л байгаа зүйлүүдийг тавьчихсан байгаад байгаа юм. Эсвэл бусад хуулиудаар тэртээ тэргүй хамгаалчихсан байгаа зүйлүүдийг давтаад ийм лоозонгийн шинжтэйгээр оруулаад ирж байгаа нь яг бодитой байдлаар бид эдийн засаг болон бизнесийн орчныг сайжруулж чадахгүй юм шиг харагдаж байна л даа.

Тэгээд 2 дахь асуудал нь болохоороо мэргэжлийн хяналтын талаар сая Энхбаяр сайд ярьж байна. 2022 онд мэргэжлийн хяналтын 1600 гаруй ажилтантай байсан, тэгээд 26 чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байсан. Тэгээд яг энэнтэй давхар бүтэц нь болохоор яамнууд дээр 1400 хүн бас давхар хяналтын чиг үүрэгтэйгээр ажиллаж байсан. Ингээд энийг нийлүүлээд 300 хүнийг орон тоог нь хэмнээд, өмнөх мэргэжлийн хяналт дээр байсан 1600 ажлаас 800-г нь яамнууд руу татан оролцуулсан юм байна. Тэгэхээр одоо Мэргэжлийн хяналтын газрыг буцаад сэргээж гаргаж байгаа юм бол тэгэхээр хүмүүсийгээ яаж бүрдүүлэх гэж байгаа юм бол, энэ бүтэц, орон тоон дээр нь та яаж төсөөлж байгаа вэ гэж харъя? Ерөнхийдөө бид чинь эдийн засгийн эрх чөлөө олгоно гээд байгаа хэр нь Мэргэжлийн хяналтын газраа буцааж гаргаж ирнэ гэдэг чинь ахиад л маш том хяналтын тогтолцоог бид ахиж

үүсгэх гээд байгаа юм биш үү гэдэг нэг ийм зүйл байна. Тэгэхээр энэ дээр хариулт авахыг хүсэж байна.

Р.Сэддорж: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: 2 бодлого зэрэгцээд явж байгаа. Нэг талдаа бизнес эрхлэх эрх чөлөөг дэмжинэ, нөгөө талдаа төрийн хяналт шалгалтын зохицуулалтыг тодорхой болгоно. Энэ 2 хамт явахгүй бол болохгүй зүйлүүд. Яагаад гэвэл нэг талдаа бизнес эрхэлж байгаа бизнес эрхлэгчдийн эрх ашиг гэж юм байна, нөгөө талд ард иргэдийн эрх ашиг гэж байгаа. Тэр хэрэглэгчийн эрх ашгийн асуудал байна. Нөгөө талаас нь хяналт зайлшгүй байх нарийн зохицуулалтууд олон салбарт орж ирж байна. Байгаль орчны чиглэл, уул уурхайн чиглэл, нөгөө уран цацрагийн асуудал, газрын ховор гээд ер нь. Тэгэхээрээ хяналтыг шинэ хяналт буюу өмнөх мэргэжлийн хяналтаас агуулгын хувьд их өөр гаргана. Зөвлөдөг, тусалдаг, дэмждэг. Зайлшгүй үндэсний аюулгүй байдал, ард түмний нийтлэг эрх ашиг зөрчвөл хатуу хязгаарладаг, зогсоодог ажлаа хийнэ. Тэгэхээр агуулгын хувьд орон тоо, төсөв дээр ямар нэгэн юу гарахгүй нэмэгдэл зардал гаргахгүй гэдэг үүрэг өгсөн. Яамнуудад байгаа салбарын хяналтуудыг нэгтгэж, зохион байгуулж, тэр хүрээндээ төсөв, орон тоогоо зохион байгуул гэдэг ерөнхий үүрэг дээр бид нарийн бүтцийг хийж байна. 3 сарын хаврын чуулганаар Төрийн хяналт шалгалтын тухай хууль энэ бүтэц, орон тоо заавал Их Хурлаар батлагдаж байж энэ маань хүчин төгөлдөр болно, энийг оруулж ирнэ гэж.

Тэр дээр нь бизнесийн байгууллага төрийн байгууллага хоёрын зөвлөлдөх механизм зайлшгүй. Тэгэхээр аливаа бизнесийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахдаа заавал энэ бизнесийн зөвлөлөөрөө дамждаг, энд хэлэлцдэг, бизнесийн зөвлөлд маань 50 хүн гэж биш юм байгаа юм. Бизнесийн зөвлөлийн 50-аас доошгүй хувь нь хувийн хэвшлийн, төлөөллийн, холбоодын, шинжлэх ухааны байгууллагын, гадаадын хөрөнгө оруулагчдаас бүрдэнэ гэж байгаа юм. Ингэснээрээ энэ Засгийн газар улс төрийн том хүсэл эрмэлзэл байхгүй юу, хувийн хэвшил, хөрөнгө оруулалтаа татъя, энэ зохицуулж байгаа 200 гаруй хууль тогтоомжийг нэлээн өөрчилъё. Зөвхөн гадаадын хөрөнгө оруулалтаар гэхэд 40 гаруй хязгаарласан, хориглосон ийм зохицуулалт байгаа юм. Энэ болгондоо эргэн харъя.

Манай эдийн засгийн нөхцөл байдал бид эдийн засгаа зайлшгүй тэлэх, эдийн засаг, зах зээлээ тэлэх, экспортод чиглэсэн, дээрээс нь гаднын хөрөнгө оруулалт таатай байж, энэ эдийн засгаа тэлэх бодлогыг хэрэгжүүлэхгүй бол одоо бол бид үндсэндээ ингээд 3,5 сая хүний зах зээл маань үндсэндээ ханаж байна шүү. Одоо яг байгаа хүчин чадалдаа тулж байна шүү. Тэгэхээрээ бид саваа томруулъя. Тэгэхийн тулд Монгол Улс бизнес хөрөнгө оруулалтад таатай улс болох хэрэгтэй. Тэгэхийн тулд бид энэ өнгөрсөн 35 жилийнхээ үйл ажиллагаанд дүгнэлт хийгээд, эрх зүйн их том өөрчлөлтүүдийг хийе.

Бид Засгаас ерөнхий энэ гол суурь бодлогын юмнууд оруулж ирж байна. Одоо би улс төрийн бүх намуудад нэг уриалмаар байгаа юм. Энэ манай Их Хурлын энэ бүрэн эрхийн хугацаанд бидний хийх хамтын том бүтээл байх ёстой. Энд манай улс төрийн намууд ажлын хэсэгт хамтран яг оролцоод, энэ бол Их Хурлын бүтээл байна. Бид өнөөдөр оны сүүлийн өдөр ингэж явсаар байгаад өргөн барьж байгаа нь оноо ингэж өгөөд, 26-ны гол зорилт бол бид бизнесийн эрх чөлөөг дэмжсэн, хөрөнгө оруулалтыг дэмжсэн, сая бид чуулганаар Зөвшөөрлийн хуулийг орууллаа шүү дээ. Энэ зөвшөөрлийг бас нэг цэгцэлчихсэн. Ер нь нэг өнгөрснөө нэг дүгнээд, эдийн засаг дахь төрийн оролцоогоо нэлээн хязгаарлаад багасгаад, цаашдаа энэ төсөв дэх

төрийн зардлыг хүртэл бид эрс бууруулахгүй бол дотоодын нийт бүтээгдэхүүнд их өндөр 37 хувь руу хүрчхээд байгаа юм. Тэгэхгүй бол бизнесийн орон зайг манай төрийн өмч, төрийн өмчтэй ААН төсвөөр дамжсан ийм шахалт их хүнд тусаж байгаа. Цаашдаа ер нь ингэж бид явж болохгүй гэсэн үүднээс, тэгэхийн тулд сууриудыг нь хийж байгаа юм.

Тунхгийн гэж та хэллээ. Тунхгийн биш, үндсэн зарчмууд хэлж байгаа юм. Өмч халдашгүй байна, бизнесийн эрх чөлөө халдашгүй байна, төр энийг.../минут дуусав/

Р.Сэддорж: Цэнгүүн гишүүн тодруулж асууна.

С.Цэнгүүн: Үндсэн хууль дээр угаасаа биччихсэн байгаа шүү дээ бид хувийн өмчид халдаж болохгүй гээд. Тэгээд тэгсэн хэр нь сүүлийн жилүүдэд хувийн өмч рүү асар ихээр халдаж байна, зах зээлүүд рүү төр өөрөө орж халдаж байна. Тэгээд энэ Эдийн засгийн зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд байгуулна гээд тэгнэ, бас нэг асуулт байгаа нь болохоор Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь тэр үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаа юм уу? Худалдаа, аж үйлдвэрийн танхим энэ дээр чинь тэртээ тэргүй тусгай хуультайгаар ажиллаад явж байгаа, ААН-үүд чинь тэр танхим дээрээ өөр өөрсдийнхөө бодлогууд, салбар зөвлөлүүдээрээ дамжуулаад нэлээн тэндээ ажиллаж байдаг. Тэгэхээр танхимтайгаа ойлголцоод явж чадахгүй байна гэсэн үг үү?

Р.Сэддорж: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Гишүүддээ хариулахад асуудалд өөдрөг талаас нь хандаарай. Танхим бол бизнесийн эрх ашгийг хангаж байгаа нэг төлөөлөл. Ерөнхий сайд бол улс орны гүйцэтгэлийг удирдаж байгаа хүний хувьд эдийн засгаа мэдрэх, хөрөнгө оруулалтын таатай орчныг мэдрэхийн тулд дэргэдээ зөвлөл байгуулж, тэр зөвлөлөөрөө дамжуулж энэ бизнест үүсэж байгаа, эдийн засагт үүсэж байгаа асуудлуудыг өөрийн манлайлал дор шийдвэрлэж байх зохицуулалт хийж байх үүднээс л байгуулж байгаа. Гэхдээ энэ бол хууль, шүүхийн шийдвэрийг давна гэсэн зүйл биш шүү дээ. Жишээлбэл арбитрын асуудал байгаа юм. Монгол Улс гэхэд л бизнестэй холбоотой арбитраж өнгөрсөн хугацаанд 6 билүү, 8 гомдлыг Монгол Улс дээр авч, олон зуун сая долларын өрөнд унаж байсан жишээнүүд их бий. Тэгэхээрээ аль болох энэ хөрөнгө оруулагчдын гомдлыг улс төрийн түвшинд түрүүлж мэдрэх, салбар хооронд зохицуулалтаар хангаад шийдвэрлэх ийм хурдан шуурхай байх үүднээс л хийж байгаа буюу нөгөө талаасаа бизнес эрхэлж байгаа, хөрөнгө оруулж байгаа улсууд дуу.../минут дуусав/

Р.Сэддорж: Нэмж 1 минут Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энэ зүгээр төсвийн зардал байхгүй, орон тоо байхгүй. Энэ зөвлөл Ерөнхий сайд хуралдаад, зөвлөлд орсон тэр байгууллагууд гомдлоо гаргаад л, асуудлаа гаргаад л, дүгнэлтээ гаргаад ингээд л Ерөнхий сайдын анхааралд л энэ хүргэх нь чухал байхгүй юу. Тэгээд шийдвэр хурдан гаргах, доор нь залруулах, заавал хууль, шүүх дээр очих биш, заавал тэр олон улсын арбитраж шийдэх асуудал биш, наана зөвшилцлөөр, хэлцлээр тэр шийдэх боломж, орон зайг нь л гаргаж өгч байгаа юм. Зүгээр улс төрийн л нэг арга хэмжээ, юу гэдэг юм бүтэц. Тэгээд Ерөнхий сайд болгон өөрөө энийгээ өөрчлөөд, шинэчлээд, урих улсуудаа уриад ингээд аваад явах бололцоотойгоор. Тэрнээс төрийн байгууллага бүтэц шиг төсвөө санхүүжих аливаа ямар нэгэн зүйл байхгүй.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байгаа, 1 минут Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Саяын хариултаас сонсоход ер нь тэгээд ямар ч төсвийн зардал байхгүй, тэгээд дээрээс нь Ерөнхий сайдтай ойр ажиллахыг хүсэж байгаа бизнесийнхэн нь өөрсдөө холбогдоод явчихдаг асуудлуудаа танилцуулаад явчхаж болно гээд тэгж байгаа юм бол заавал хуульчилж өгөөд байх шаардлагагүй л юм шиг харагдаад байна л даа надад бол. Яагаад гэхээр яагаад заавал тэрийг хуульчилж өгөх ёстой гэж. Одоо манай улсад чинь бүх зүйлүүдийг ингээд хуульчилж өгдөг. Асуудал гарангуут бид нэг дунд нь тусад нь тусгайлчихсан нэг зөвлөл байгуулсан, тэр зөвлөл дээр асуудлаа ярина гээд. Өмнө нь төрийн албаныхан тус тусдаа нэг очиж элдэв бусын зөвлөгөө нэртэйгээр хамаг цаг хугацаагаа бардаг байсан бол одоо хувийн хэвшлийнхнийгээ бас ажил хийлгэхгүй элдэв бусын зөвлөгөөнүүд дээр бид дуудаж, дууддаг болох юм уу? Тэр зөвлөлд орж байгаа хүмүүс Худалдаа, аж үйлдвэрийн танхим дээр бүртгэлтэй л компаниудын захирлууд очно. Ер нь нэг манайд тийм олон ч тийм компанийн захирлууд байхгүй тэртээ тэргүй. Тэгэхээр чинь нэг эргүүлж харж танхим дээрээ хуралдаад л, нөгөө талдаа Ерөнхий сайдын зөвлөл дээр очиж хуралдана гээд нэг ийм л ажил хийдэг нэг газар болж хувирах гээд байна шүү дээ.

Р.Сэддорж: Хариулт Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Нэг талдаа зөвхөн бизнесийн эрх ашиг биш шүү дээ, энд судлаачид оролцоно, мэргэжлийн холбоод оролцоно, эрдэмтэд оролцоно, нөгөө талаас хэрэглэгчдийн бас эрх ашгийн төлөөлөл оролцоно. Танхим гэдэг цэвэр бизнесийн эрх ашгийг хамгаалдаг байгууллага. Тэгэхээр Ерөнхий сайд улс төрийн шийдвэр гаргахад бүх энэ салбарын төлөөллийг сонсож байх нь их чухал байгаа юм. Энэ их өөр байна, Цэнгүүн гишүүнээ асуудалд жоохон өөдрөг ханд, бүгдээрээ болгоё, бүтээе гэж. Би хэлээд байна шүү дээ. Энэ бол манай парламентын хамтын бүтээл болно. Тийм, өнгөрсөн 35 жилээ нэг дүгнээд, дүрэм журмаа, бизнесийнхээ дүрмийг жоохон шинэчилж байгаа л үйл явдал шүү дээ. Тийм, тэгээд бүгдээрээ хамтраад ажлын хэсгээ гаргаад, хамтраад бүх улс төрийн намууд оролцоод, та бүгд.../минут дуусав/

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Анар.

Ч.Анар: Өдрийн мэнд эрхэм гишүүдээ. Энэ хуулийн агуулга, үндсэн зорилгыг нь ойлгоод дэмжиж байна. Тэгээд манайд нөгөө Чөлөөт бүсийн тухай хууль, Аж үйлдвэр, технологийн паркийн тухай хууль гээд нөгөө эдийн засгийг тэлэх зорилготой маш олон хуулиуд байгаа, Гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль гэх мэтчилэн. Энэ хуулиудыг нөгөө өндөр технологийн тусгай бүс байгуулах хуулийн ажлын хэсэг 6 гишүүн явж, нэг жил гаруйн хугацаанд судалсан. Тэгээд энэ хуулиудын хэрэгжилтээ судлаад харахад ерөөсөө хэрэгжээгүй. Шалтгаан нь юу юм бэ гэхээрээ оролцогч талтайгаа Засгийн газар болон хуулийн ажлын хэсгүүд ерөөсөө уулзаж үзээгүй байдаг юм билээ. Ямар хөрөнгө оруулалт татах гэж байгаа юм, ямар хүндрэл бэрхшээлүүдийг хийх гэж байгаа юм. Тэгээд нөгөө ажлын хэсгүүд маань нэг цуглаад хуралдаад, саналыг нь аваад, яг бодит бэрхшээл нь хаана байна вэ гэдэг нарийвчилсан судалгаа ерөөсөө маш дутуу хийдэг учраас манай Чөлөөт бүсийн тухай хууль дээр хөрөнгө оруулалт орж ирдэггүй, эдийн засаг тэлдэггүй.

Тэгэхээр энэ Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг агуулгын хувьд дэмжиж байгаа ч гэсэн би бас энэ зарим гишүүдтэй санал нийлээд байгаа нь тунхгийн биш, ерөнхий агуулга, зарчмын шинж чанартай ороод байна. Тэгэхээр

хуулиудыг энэ удаа журмаар бага зохицуулаад, илүү нарийвчилж оруулж ирье гэдэг агуулгыг парламент бариад байгаа юм. Тэгэхээр энэ анхдагч хуулийг илүү нарийн зохицуулалттай оруулж ирэх боломж байгаагүй юм уу? Энэ судалгааг яагаад, энэ чинь аягүй том хууль шүү дээ Энхбаяр сайдаа, та тэгэхээр энийг зоригтой хөндөж байгаад талархаж байна. Зүгээр илүү их л нарийн зохицуулалттай, их удаан хугацааны судалгаатай орж ирэх ёстой байх гэж харж байгаа юм.

2 дугаарт тэр Цэнгүүн гишүүнтэй санал нэг байна. Засгийн газар доороо орон тооны бус 9 гишүүнтэй байх ба Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батална. Тэгэхээр нөгөө Танхимын тухай хууль одоо шинээр орж ирэх гэж байгаа. Танхимтайгаа давхардсан чиг үүрэгтэй, тийм. Тэгэхдээ энэ маань эргээд илүү хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахад биш, илүү хүнд суртал болоод, дахиад л нөгөө нэг төрийн давхар бүтэц нэмэгдчих юм биш байгаа гэдэг л санаа зовсон асуудал үүсээд байгаа юм л даа. Яагаад танхимаараа дуу хоолойгоо хүргээд, танхим чинь ч гэсэн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах үүрэгтэй газар. Энэ бүтэц нь өөрөө эргээд ямар 9 хүн байх юм, яаж сонгох юм, хууль дээрээ байхгүй, Засгийн газар Хөрөнгө оруулалтын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн тухай журам гэж гаргах юм болчихлоо л доо энэ хуулийг харахаар. Тэр журам чинь үзэмжээрээ сольдог асуудал болох гээд байна. Энэ 2 асуудалд хариулт авъя.

Р.Сэддорж: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Засгийн газрын тэргүүн бүрэн эрх хэрэгжүүлэх хугацаандаа өөрөө энэ дэргэдэх зөвлөлөө байгуулаад л, Засгийн газартаа танилцуулаад ингээд л явах нь зүйтэй. Энийг хуульчлаад л, нэг байгууллагажуулаад л доторх үйл ажиллагааг нь хуулиар заах, нарийвчлах шаардлагагүй. Мэдээж танхим бол нэг хүн нь байх нь тодорхой, нэг төлөөлөл байх нь тодорхой. Танхим зөвхөн бизнесийн ашгийн төлөө байгууллагуудын эрх ашгийг хамгаалж байгаа. Нөгөө талд хэрэглэгчийн эрх ашиг гэж байна шүү дээ. Тэрийг та нар тооцож үзээч. Шинжлэх ухааны байгууллагууд, судлаачдын асуудлууд байна. Энэ манай юм маань зөв байна уу, буруу байна уу, бодлогын алдаа, оноо гэдэг чинь бусад хөндлөнгийн оролцоог заавал шаардаад байгаа юм. Тэгээд энийгээ тэр хүрээнд гэж нэг ойлгочихвол их зүгээр байгаа юм.

Тэгээд тунхаглаж байж процесс хуулиуд дараа нь гарна. Маш олон процесс хуулиуд байгаад байгаа юм, 200 гаруй хууль байна бизнесийн зохицуулалтын хууль. Үндсэн нэг язгуур юмнуудаа их дутуу хийчихсэн, нөгөө өмчийн халдашгүй байдлын асуудал, төрийн эдийн засаг дахь оролцооны асуудал, бизнесийн үндсэн тэр зарчмууд. Энийгээ бид нэлээн гаргаад өгөхөд цааш цаашдаа яг энэ дээр, энэ тунхаглал буюу энэ үндсэн зарчим дээр суурилж бусад процессын хуулиудад өөрчлөлт ороод явна. Аливаа хууль, шүүхийн маргаан үүсэхэд энийгээ барьж эхэлнэ. Үндсэн суурь зарчим чинь энэ байна шүү дээ. Миний бизнесийн нэр хүндийг төр ингэж халдаж болохгүй, энийгээ төрийн байгууллага энийгээ зөрчсөн тул миний бизнесийн нэр хүнд сэргээгдэх ёстой. Төр ийм зарчим байгаад энэ хууль нь байгаа тул миний өмчийг дайчлан хурааж болохгүй. Зөвхөн ийм, ийм шалтгаан, ийм нөхөн олговор байх ёстой буюу эргээд нөгөө бизнесээ хамгаалах, бидэнд нөгөө өмчийн эрхийг хамгаалж чадаагүй их олон жил явчихсан.

Ерөнхийдөө бизнес хийх бололцоотой гэж аваад байсан мөртөө энэ ирж байгаа энэ гомдол, өргөдөл тэрний учир шалтгаан энэнтэй л холбоотой. Эдийн засаг дахь төрийн оролцоо, тэгээд төрийн аппаратаар дамжиж байгаа олон зөвшөөрлийн шат дамжлага, тэгээд хууль хяналтын байгууллагад очиж байгаа тэр

гомдол хэрэг маргаан шийдвэрлэж байгаа процесс дэндүү удаан, дэндүү муу байна. Тийм болохоор хөрөнгө оруулалт чинь үндсэндээ зогсчоод байна, эдийн засаг чинь ингээд ханачхаад, цаашид тэлж өгөхгүй болчихоод байна. Бизнес хийх идэвх, урам зориг сулраад байна шүү дээ. Өнөөдөр бид гэхэд л хар л даа, төсөв дээрээ ингээд ямар асуудал үүсээд сууж байгаа билээ. Тэгэхээр эдийн засгаа зайлшгүй тэлнэ, тэлэхийн тулд бид таатай байна, хөрөнгө оруулалтыг татъя, хөрөнгө оруулагчдынхаа эрх ашгийг гадаад, дотоод гэхгүй хамгаалъя.

Стратегийн гол, гол салбараа бол харин төр хамгаалсан шиг хамгаална. Гол нь өмчийн эрх, бизнесийн эрх чөлөөг, хөрөнгө оруулалт авчраад л нэг геологи хайгуул хийх, сайн дурын уран сайхан, сайн дурын тэр зохион байгуулалттай улсууд ороод л тэрийг нь юмыг нь эвддэг, сүйтгэдэг, дайрдаг. Энд тэр хүн төр хамгаалах ёстой гээд зогсож байх ёстой байхгүй юу. Танай бизнесийн үндсэн зарчим энэ байна Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний, хөрөнгө оруулалтыг ингэж хамгаалах ёстой, тэгээд ийм мэтийн маш олон зүйл бидэнд үүсчхээд байна шүү дээ. Тэгэхээр энийгээ нэг сайхан шийдээд, тэгээд ажлын хэсэг байгуулаад, манай гишүүд идэвхтэй оролцоод бүгдээрээ энэ 1 сар, 2 сар, 3 сар дамжсан нийтийн хэлэлцүүлгүүд санал бодлыг нь сонсоод, энэ хууль бол бид суурийг нь аваад ороод ирж байгаа юм. Одоо энэ дээрээ бүгдээрээ том байшингаа гаргаад, сайн эрх зүйн орчин бүгдээрээ хамтдаа л бүтээе гэж уриалж байгаа юм л даа. Тэгэхээрээ хийх ажлууд их байгаа юм.

Зарим зүйл дээр албаар дагалдах хуулиудыг нь хасаад ороод ирсэн. Яагаад гэвэл гишүүдийн хэлэлцүүлгийн зарчимд заавал улс төрийн шийдэл гаргах юмнууд их байна. Гаднын хөрөнгө оруулалт 40 гаруй хуулиар хязгаарлаж байна бид олон хориглож байгаа зүйлүүд байна. Энэ дээр бид улс төрийн шийдэл гаргах юмнууд байна. Энэ дээр нээе, энийг нь хатуу барья энэ болгон чинь дандаа улс төрийн шийдлүүд. Тийм болохоор энэ Их Хурлын парламентын хамтын бүтээл байх ёстой гэж би бодож байгаа.

Р.Сэддорж: Анар гишүүн тодруулж асууна.

Ч.Анар: Энхбаяр сайд та агуулга, зарчмыг нь яг зөв ойлгоод асуудлаа ярьж байгаа. Тэн дээр орж ирж байгаад нь дахиад хэлье санал нэгтэй байна. Гэхдээ санаа зовж байгаа зүйл нь маань Монгол Улсын Их Хурлын гаргаж байгаа ихэнх шийдвэрүүд нийгмийн салбарын бодлого тодорхойлогчид маш их, эдийн засагч, инженер, орчин үеийн бизнесменүүд маш цөөхөн учраас ерөөсөө бодит асуудал дээр хөрөнгө оруулагч гадна, дотнын хөрөнгө оруулалт, бизнесийн зовлон бэрхшээлийг мэдэхгүй хүмүүс маань ихэнхдээ хууль тогтоогоод байгаа байхгүй юу. Яагаад гэвэл ерөөсөө яг бодит байдал дээрээ юу болдог вэ, санаа сэдэл нь зөв ч гэсэн бодит практик процесс дээрээ аягүй асуудалтай хуулиуд гаргачихдаг. Тэгэхээрээ нөгөө хуулиуд маань эргээд орчноо нээж өгөхөөс илүү хүндрэлтэй нөхцөлүүдийг үүсгээд байдаг. Төрийн аппаратууд маань тэрийгээ ашигладаг. Тэгэхээр ажлын хэсэгт орж ажиллах саналтай байна.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Очирбат.

Г.Очирбат: Тодорхой хэдэн асуултууд байна. Энэ хуулийн төсөл бол нэр нь их гоё боловч судалгаа их дутуу хийгдсэн байна. Өнөөдөр энэ хуулийг дагаад олон хуулийн төслүүд орж ирэх ёстой. Ялангуяа энэ ААН-үүдтэй холбоотой Компанийн тухай хууль, Төрийн өмчит компанийн тухай хууль ингээд орж ирэх ёстой, Үйлдвэр, технологийн паркийн тухай хууль орж ирэх ёстой. Аягүй гоё, гоё хуулиуд оруулаад

ирдэг мөртөө амьдрал дээр хэрэгждэггүй, энэ Их Хурлын гишүүд бүгд хэлж байна. Тэгээд энийгээ дагаж оруулж ирэх ёстой. Зарчмын хувьд одоо ингээд зөвхөн ААН-үүдэд 2 хууль үйлчилж байгаа. Компанийн тухай хууль гэж тусдаа явдаг, Төрийн өмчит компанийн тухай хууль гэж явдаг. Энэ зарчмын хувьд ийм байх ёстой юу, үгүй юу асууя даа Энхбаяр сайдаа нэг?

2 дахь асуулт ингээд зөвлөл байгуулах гэж байгаа юм байна. Тэгээд мэргэжлийн холбоонуудтайгаа хамтарч ажиллана гэж байгаа. Тэгэхээр энэ хуулийг дагаад Монгол Улсын Засгийн газрын тухай хууль дахиж орж ирэх ёстой байсан. Яагаад гэхээр Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19.1, 2 дээр ялангуяа мэргэжлийн холбоонуудтай төр өөрийнхөө чиг үүргийг өгч хийж, гэрээ хийж, санхүүжүүлж ажиллаж болно гэчихсэн байгаа. Тэгээд тэр гүйцэтгэлээ тухайн хариуцсан сайдынхаа өмнө, салбарын сайдын өмнө хариуцна гэж байгаа юм. Тэгэхээр энэ чиг үүрэг чинь төр өөрөө тэр зөвлөл байдаг юм уу, тэр мэргэжлийн холбоодод байдаг юм уу санхүүжилт өгчхөөд, яаж буцаагаад хяналт тавих гээд байгаа юм бэ? Одоо төр яг хэчнээн ийм төрийн бус байгууллагуудад санхүүжилт өгчихсөн байгаа юм бэ? Энийг танаас сонсчихмоор байгаа юм.

Дараагийн асуулт гаднын хөрөнгө оруулалтаа яриад байна, их л гоё гэгээлэг юм яриад байна. Бид парламентаар хууль тодорхой, чиг үүрэг нь тодорхой, журмуудыг халъя гэж байгаа юм. Энэ хуулийн төслийг дагаж 2 хуулийн төсөл орж ирж байгаа. Гаднын хөрөнгө оруулалттай холбоотой 8.2-оос 8.5 хүртэл 5 журам батална гэж байгаа юм. Тэгээд салбар дээрээ очоод өөрийнхөө дураар журам баталдаг, өөрийнхөө эрхшээлд байлгадаг. Эрчим хүчний салбар дээр энэ бүүр тодорхой гарч байгаа шүү дээ. Нэг сэргээгдэх эрчим хүчний 20 квт-ын юм өрх өөрөө хийчхээд холбоё гэхээр 2, 3 сараар нь холбож өгдөггүй, салбарын холбоотой журмууд нь хаагаад боочихдог ийм байдалтай байгаад байгаа. Тэгэхээр энийгээ юу гэж харж байгаа юм бэ?

Дараагийн дагаж орж ирсэн хууль бол энэ Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах гэххэж байгаа юм. Монгол Улсын гэдгийг авч хаясан байна. Урьд нь яаж явж байсан юм бэ? Асар олон энэ Филиппиний хаанахын хаанахын ч билээ хүмүүс орж ирж хүүхэд харж байсан. Урьд нь хууль зөрчиж явж байсан юм уу, яагаад энэ хуулийн төслийг оруулж ирж байгаа юм бэ?

Хамгийн сүүлийнх нь манай энэ Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн 7.5 дээр хувийн өмчийг хууль бусаар шууд болон шууд бус хэлбэрээр хураан авахыг хориглоно. Зөвхөн нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн үл ялгаварлах, хуульд заасан үндэслэл журмын дагуу нөхөн олговортойгоор хураан авч болно гэчихсэн байгаа. Энэ яах вэ Үндсэн хуулийн 16.3-ыг яг барьсан байгаа юм өгүүлбэрээр нь. Тэгэхдээ танаас асуух гэж байгаа асуулт бол урьд нь хэчнээн ийм ААН-үүдийг боож хааж юмыг нь хурааж авсан юм бэ? Миний мэдэхийн буутай очоод очоод л, бөөн сүр болоод л хувийн хэвшлийг дарамтлаад л, гаднын хөрөнгө оруулагч үргээгээд л явж байсан тохиолдол байдаг нэг. Тэгээд энэнтэй холбоотой хэчнээн тохиолдол тоо судалгаатай нэг хариулт авчихъя? Тэгээд тодруулъя. Үндсэндээ ингээд 4, 5 асуулт.

Р.Сэддорж: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ хөрөнгө оруулалттай холбоотой маргаанууд хөрөнгө оруулагчийн итгэлийг алдаж залилж байгаа, булааж байгаа хүч хэрэглэсэн ийм холбоотой 13 гомдол яг байгаа юм. Их Британийн иргэн гэж байна. Нөгөө Ерөнхий сайд Борис Жонсоны дүү байна шүү дээ Засаг Чандмань Майнз гээд компани байгаа

юм. Нийт энэ төсөлд 19 сая доллароор хөрөнгө оруулалт хийгээд явсан, хамтрагч иргэн нь хөрөнгө оруулалт нь хувьдаа завшаад, Америк руу зугтаад гарчихсан нэг асуудал байж байна. Бигом Чойр гээд компани байгаа юм. Бас л уул уурхай төмрийн хүдрийн үйлдвэртэй холбоотой. Энэнтэй холбоотой булааж авсан асуудал гарсан. Энийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох байгууллагад үүрэг өгөөд шийдвэрлэж, гомдлын ард гарсан байх жишээтэй.

Ингээд Эдийн засаг, хөгжлийн яаман дээр энэ хөрөнгө оруулалттай холбоотой гомдлууд төвлөрөөд байгаа юм байна. Тэгээд энэний араас яам өөрөө хөөцөлдөж, хууль, шүүх бүх процесс дээр явж байна. Энэ дээр нөгөө юунууд нийт 120 гомдол байна. Тэгээд одоогийн байдлаар 47 орчим гомдол шийдэгдсэн, шийдвэрлэгдсэн, шүүхийн шатанд гээд юм явж байна, тийм 120-оод гомдол байгаа юм.

Нэг юуны асуудал байна, ингээд гомдол үүсэхээр юу руу орно арбитр луу хандана, арбитр дээр Монгол Улс эргээд яг энэ бизнестэй холбоотой олон юман дээр унаж байгаа. Олон, олон сая, арван сая доллар, зуун сая долларын өрөнд орсон тохиолдлууд их гарч байна. Төрийн өмгөөллийн зардал дунджаар 5,1 сая доллар, шүүхийн зардалд 1 сая доллар гарч байгаа арбитрын олон улсын арбитр. Жишээлбэл Хан ресурс гээд 2015 оны асуудал шүү дээ, олон улсын арбитрын шүүхэд Монгол Улс 80 сая доллар төлсөн байгаа юм шийдвэр гаргаад гэх мэтийн юмнууд гараад байгаа юм. Тэгэхээрээ заавал арбитрт хүрэхгүйгээр энэ зөвлөлөөр дамжуулаад, Засагт улс төрийнх нь шийдвэр гаргах дээд эрх мэдэлд нь гомдлоо өгөөд, тэр зөвлөл нь энэний нөгөө өмнөөс асуудал тавиад, ингээд нэг зохицуулдаг, хууль шүүхээс очихоос өмнө ингээд зөвшилцөл, хэлцэл хийдэг, эвлэрдэг тэр боломжийг нь нээж өгөх ийм шаардлага үүсээд байна л даа.

Тэгээд ийм ижил төстэй улсуудын жишээ байна Гүрж, Эстони, Бразил, Польш гээд улсууд. Ердөө л Эдийн засгийн эрх чөлөөний хуулиудаа батлаад л, яг гол, гол зүйлүүдээ тунхаглаад л дандаа бизнес, хөрөнгө оруулалтаа хамгаалсан хуулиудыг хийсэн. Энэнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалт, эдийн засгийн өрсөлдөх чадвар нь дандаа эерэг гарсан зүйлүүд байна. Тэгэхээрээ манайд 35 жилийн бизнесийн түүх үүслээ. Одоо бид их олон зүйлийг мэдэж байна шүү дээ, юу хийх вэ, юу хийхгүйгээ ойлгоод эхэлчихсэн. Тэгэхээрээ одоо нэг энэ бизнесийнхээ дүрэм журмыг нэг тодорхой болгоод ингээд явчихъя. Деталь болгон гэвэл эдийн засаг чинь томорчихсон, салбар болгоны юм зохицуулалтаар нэг хуулиар болохгүй. Бүх хууль 200 гаруй хуулиар зохицуулж байна. Тэр хуулийн малгайд өмнө нь тавих юм чинь үндсэн зарчмыг нь гаргаж өгч байгаа байхгүй юу. Энэ хууль хэрэгжихдээ энэ, энэ эдийн засгийн зарчмуудыг хувийн.../минут дуусав/

Р.Сэддорж: Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Орохгүй ээ, ингээд орвол би хэлж байна шүү дээ 200 гаруй хууль ороод. Чи намайг ойлгохыг хүсвэл ойлгоно, ойлгохыг хүсэхгүй бол ойлгохгүй. Үндсэн суурь зарчмуудыг нь тунхаглаад баталгаажуулаад өгье, энийгээ дагаад бүх бусад процессын хуулиуд, салбарын зохицуулалтын хуулиуд энэ салбарт нийцнэ гэж байгаа юм хийхдээ. Би мэдэхгүй байна, мэдээлэл алга, тэгээд тодруулаад өгье.

Р.Сэддорж: Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: Энэ мэргэжлийн холбоонуудаа бид чинь ингээд дэмжээд бойжуулаад явах ёстой. Тэгэхээр яг Засгийн газрын тухай хуулийн 19.1, 2 дээр энэ

мэргэжлийн холбоонуудад чиг үүргийн дагуу төрийн чиг үүргийг ингээд хэрэгжүүлж ажил хийлгүүлнэ гээд бараг заачхаад байгаа юм. Тэгэхээр бид ингээд нэг талдаа нөгөө мэргэжлийн холбоонууд бие даасан байдлаар шийдвэр гаргаад, Засагт ингээд ажлыг нь сайжруулахад зөвлөгөө, тусламж үзээд л явах ёстой байтал нөгөө гараараа хууль баталчихсан, тэр төр өөрийнхөө чиг үүргүүдийг мэргэжлийн холбоодоор хийлгэнэ гээд санхүүжүүлж байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо хэчнээн мэргэжлийн холбоонуудад санхүүжилт өгдөг юм бэ гэж би тодорхой танаас асуугаад байгаа шүү дээ? Миний мэдэхийн хэлбэл жишээ нь 3, 4 юм байна. Тэгээд би танаас асуугаад байгаа юм.

Р.Сэддорж: Энхбаяр сайд тодорхой хариулъя.

Ж.Энхбаяр: Надад яг энэ хэчнээн холбоог санхүүжүүлж байгаа мэдээлэл алга. Жишээлбэл би сая хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг хариуцахад манайх 25, 6 мэргэжлийн холбоодтой байсан. Махны холбоо, Сүүний холбоо, Тариаланчдын холбоо, Гурил үйлдвэрлэгчдийн холбоо, Тоног, төхөөрөмжчдийн холбоо эд нар гээд холбоод нь гээд. Бид ямар нэгэн санхүүжилт хийж өгч үзээгүй. Харин холбоодтойгоо хамтран ажилладаг байсан. Тухайн компанитай ажилладаггүй байсан, нэг үйлдвэр, зөвхөн холбоогоор дамжуулж төртэй хамтардаг, холбоогоор дамжуулж гомдлоо шийдвэрлүүлдэг, салбарт хэрэгжих бодлого холбоогоор дамждаг. Тэр л нэг зарчмын зүйлийг л энэ зөвлөл дээр оруулж ирж, журамлаж өгч байгаа юм шүү дээ. Энэ дээрээ бид олон юм алга даа, бизнесийн хэдхэн голлох зөвлөлүүд байна, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалдаг хэдхэн зөвлөл байна. Судалгаа, шинжилгээний шинжлэх ухааны 2, 3-хан байгууллагууд байна. Энэ хэдийгээ бид тооцоод 9 дотор байгаад илүү үр дүнтэй байхад нэг цуглаад л, Ерөнхий сайдад эдийн засгийн орчин чинь ийм байна, бизнес явуулах эрх чөлөөнд гомдол санал ингээд байна, энэ салбарт хүндрэл.../минут дуусав/

Р.Сэддорж: Очирбат гишүүн хариулт хангалтгүй гэж 1 минут.

Г.Очирбат: Тэгээд харин Энхбаяр сайдаа дутуу байна гэж анх хэлж байгаа чинь л тэр байхгүй юу. Ядаж энэ чиг, Засгийн газар өөрөө энэ чиг үүргээ энэ хуулийн төслийг дагуулаад бодлогын юм ярьж байвал авчих ёстой байхгүй юу. Засгийн газрын тухай хуулийн 19.2, 3 хоёр одоо хүчингүй болж байгаа юм гээд энэ яг энэ 2 хууль өргөн барьж байгаатайгаа адилхан нэмэлтээр энэ заалтууд байхгүй болно гэдэг л зарчмын хувьд та оруулаад ирэх ёстой байсан юм. Тэгэхээр энэ судалгаа дутуу байгаад байна, хийгээгүй байна, ерөнхийдөө тунхгийн чанартай байгаад байна, нийгмийн олон талт хэлэлцүүлэг хийгдээгүй байна л гэдэг санааг хэлээд байгаа юм. Мэргэжлийн холбоонууд маань бол яах вэ гэхээр Засгийн газартай хамтарч ажиллахаас илүүтэйгээр өөрсдийнхөө тэр салбарынхаа ААН-үүд, иргэдтэй уулзаад, тэндээ санаа оноог нь аваад, гишүүнчлэлээрээ төсөв мөнгөө босгоод, нэг бол тэр компаниудтайгаа уулзаж ярилцаад татвараа тогтоогоод, тэрүүгээрээ төсөв мөнгөө босгоод, бодлогоо гаргаад, Засгийн газар луу ингээд 3 талын уулзалтад ороод явж байх ёстой шүү дээ. Энэ л зарчмыг хэлээд байгаа юм. Түүнээс энэ концепц нь гоё байгаад байгаа шүү дээ.

Р.Сэддорж: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Ер нь тэр бизнесийнхээ зөвлөл буюу энэ чинь төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх механизмыг жоохон өндөр өргөж, статусыг нь Ерөнхий сайдын хажууд авчирч тавьж байгаа зүйл шүү дээ тэр талаас нь харчихмаар байгаа юм.

Тэнд яагаад гэвэл нэгэнт хуулиар хувийн хэвшилд өндөр эрх олгож байгаа байхгүй юу. Та төртэй зөвшилцөнө, бизнесийн салбарт үүсэж байгаа хүндрэл бэрхшээл, хөрөнгө оруулалт, тулгарч байгаа асуудлыг тэр түвшинд ирж Ерөнхий сайдад хэлэх тэрийг нь л хуульчилж өгч байгаа юм. Одоо энэ зүгээр сайн дурын тэр тухайн Ерөнхий сайдын үзэмжийн асуудал байгаа байхгүй юу. Зарим сайдууд энийг хийдэг, зарим хийдэггүй. Тэгэхээр та заавал энийг энэ мэдрэмжийг авахын тулд Ерөнхий сайд ийм зөвлөлийг байна гэдэг нь их чухал байхгүй юу даа. Тэр талаас нь нэг хараадхаач.

Хүүхэд харахтай холбоотой, нийт 40-өөд хууль байна гаднын хөрөнгө оруулалтад ялгамжтай хандсан. 41 хууль дотор бид 41 хууль маань 47 зохицуулалтаар хязгаарлаж байгаа юм. Энийг нь ингээд шүүгээд яг үндэсний аюулгүй байдал.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут.

Ж.Энхбаяр: 40 хуулийн 47 орчим зохицуулалтыг гээд үзэхээр 27 нь хасагдаж байгаа юм. Энэ бол зайлшгүй гаднын хөрөнгө оруулалтад хязгаарлалт тавих ёстой гэж үзэж байгаа зүйлүүд бий. Түүнээс гадна 20 гаруй зохицуулалтууд байгаа юм. Энэ 20 гаруйн жишээг нь нэг болгоод би энэ хүүхэд харах үйлчилгээ буюу хамгийн энгийн зүйлийг нь нэг гээд оруулчихсан юм. Хэлэлцүүлгийн явцад энэ бол 10, 20, 30 болж хөдлөх ёстой. Би хэлэлцүүлэг маань жоохон амттай, гишүүд маань санал гаргаад, жоохон бүтээлч байх орон зайг нь, нөгөө талаас энэ дотор чинь улс төрийн шийдэл хэрэгтэй байгаа байхгүй юу. Энэ чинь Монгол Улсын парламент улс төрийн шийдвэр гаргаад, энийг гаднын хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулахыг хязгаарлах шийдэл гаргана, нэг бол нээх шийдэл гаргана. Манай бидний бодлоор энийг 50 хувийг нь яах вэ энэ цаг үед хязгаарлаад, 50 хувийг нь нээчихье гээд байгаа юм. Гэхдээ энэ нээх юмаа ахиад улс төрийн шийдэл буюу энэ хамтарсан ажлын хэсгээрээ хэлэлцүүлэх нь зүйтэй гэдэг бодлоор нэг гээд цэг тавьчихсан байхгүй юу. Цаана нь 20 гаруй орон зай байна.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу.

Ч.Лодойсамбуу: Энэ хуулийг нэрээс нь өгсүүлээд ер нь дэмжихгүй байгаа, гишүүдтэйгээ санал нэг байна. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал муу байна, эдийн засгийн эрх чөлөөний нөхцөл байдал муу байна гэнгүүт нь тэгвэл Эрх чөлөөний нэртэй хууль батлаад өгчихье гэж байгаа юм шиг ийм нүд хуурсан юм шиг л харагдаад байгаа юм. Миний ойлгож байгаагаар эдийн засгийн эрх чөлөө гэдэг маш олон хуулиуд хамтдаа өргөж босгодог ийм процессыг хэлээд байх шиг байгаа юм. Тэрнээс яг Эдийн засгийн эрх чөлөөний хууль гэж нэг хууль гаргаж ирж, нэг суваг гаргаж ирж, түүгээрээ олгоод, тэгээд эдийн засаг нь жигтэйхэн тэлээд ингээд явчихдаг зүйл биш. Ойлгохгүй байгаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйл, 16 дугаар зүйлээр эдийн засгийн эрх, эрх чөлөөгөө үндсэндээ баталгаажуулаад өгчихсөн. Тэгээд энийгээ амилуулах бусад та хэлээд байна л даа энэ 200 гаруй хууль, төчнөөн хуулийг засах шаардлагатай гээд. Уг нь Эдийн засгийн хөгжлийн яамнаас яг энэ эдийн засгийн эрх чөлөөг боомилоод байгаа хуулиудын нэмэлт, өөрчлөлт орж ирэх ёстой баймаар байгаа юм. Өмнөх Гантөмөр сайдын үед уг нь оношилгоо нь овоо явж байсан, Эдийн засгийн хөгжлийн яаман дээр бараг бэлэн л байх ёстой доо. Яг ямар хуулиуд бизнес эрхлэхэд саад учруулаад байгаа юм, ямар хуулиуд нь энэ төрийн оролцоог нэмээд байгаа юм, ямар хуулиуд нь тээг тушаа болоод байгаа юм бэ гэдгийгээ оношлоод

л, тэр өөрчлөлтүүдийг л Эдийн засгийн хөгжлийн сайд нь барьж ирж орж ирмээр санагдаад байх юм.

Энэ хуулийн заалтууд дээр жишээ нь ямар ч шинэ юм байхгүй гээд түрүүн Цэнгүүн гишүүний хэлж байгаатай санал нэг байна. Жишээлбэл энэ 7 дугаар зүйл дээр хэцүү, хэцүү заалтууд байна л даа, 7.1 түрүүн жишээ дурдсан. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаас бусад тохиолдолд төрөөс эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан гэж байгаа юм. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, нийтийн ашиг сонирхол гэж нэгд юуг хэлж байгаа юм бэ?

2-т 7.5 дээр тэр хувийн өмчийг шууд болон шууд бус хэлбэрээр хураан авахыг хориглоно. Энэ нь зөвхөн нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэнэ. Нийгмийн зайлшгүй хэрэгцээ гэж юуг томъёолж байгаа юм бэ? Одоо энэ нөгөө нэг худал мэдээлэл тараавал гэдэгтэй адилхан бас энэ мөрдөн байцаалтын нууц задруулна гэдэгтэй адилхан нэг ийм яаж ч тайлбарлаж болдог ийм пүүл үүсгэхээд байгаа чинь л, манай энэ хуулиудын зохицуулалт нарийн биш байгаа чинь ингээд асуудал үүсгээд байгаа шүү дээ. Бусад энэ зах зээлд сөргөөр нөлөөлөөд байгаа энэ эдийн засгийг тэлэхэд тээг тушаа болоод байгаа энэ хуулиудын өөрчлөлт хэзээ орж ирэх юм бэ? Саяын энэ зөвшөөрлийг цэгцэлье гэдэг чинь Учрал даргын санаачилсан хууль. Энэ хуучин ЗГХЭГ-ын дарга байхдаа санаачилсан. Энэ Засгийн газраас ер нь эдийн засгийн эрх чөлөөг хангах талаар энэ нэг ийм энэ гарчгаас өөр яг юу оруулж ирэх юм бэ? Бусад энэ эдийн засгийн эрх чөлөөг хааж боогоод байгаа хуулиудын өөрчлөлт орж ирэх юм уу, үгүй юм уу? Энэ асуултад хариу.

Р.Сэддорж: Энхбаяр сайд хариулья.

Ж.Энхбаяр: Энэ баялаг бүтээгчдээ дэмжих энэ багц бодлогын хуулиудыг оруулах энэ бодлогын хүрээнд энэ хуулиуд байгаа. Манай дээр энэ Эдийн засгийн эрх чөлөөний хууль болон Хөрөнгө оруулалтын хуулиа, Их Хурлын дарга Зөвшөөрлийн хуулиа энэ бүгд манай яаман дээр боловсрогдсон хуулиуд шүү дээ Зөвшөөрлийн хуулиуд. Удахгүй бид хаврын чуулганд Худалдааны хуулийг оруулж ирэхээр зохицуулалтын хуулийн бичилт яг хийгдэж байна. Худалдаа зохицуулалт Монгол Улсад байхгүй, хуульгүй байгаа. Дээрээс нь даатгалын асуудал байгаа бас зохицуулалтгүй олон зүйл. Сүүлийн бараг 10-аад жил санхүүгийн салбарын хууль, эрх зүйн орчны бодитой өөрчлөлтүүд ерөөсөө ороогүй байна. Энэнтэй холбоотой санхүүгийн салбарын зүйлүүд нэлээн орох.

Ер нь эдийн засаг дахь аль болох төрийн оролцоог багасгах, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа төсвийн хэмжээг багасгах, аль болох эдийн засгаа тэлэх, экспортод чиглэх, хөрөнгө оруулалтыг татах энэ бодлогын хүрээнд энэ багц хуулиуд ээлжлээд, ээлжлээд яам яамд хуваарилагдаад, хийгдээд, боловсрогдоод явж байгаа. Тэгээд анхны хуулиуд нь орж ирж байгаа нь энэ. Мөн Ашигт малтмалын хууль, Ашигт малтмалын хууль гэхэд л гол хөрөнгө оруулалтыг гол татаж байгаа уул уурхайн ашиглалтын салбарыг бид эрэл хайгуулын ажил, тэр олон гацаа болж байгаа тэр роялти өсөн нэмэгдэх болон тэрний хувь хэмжээ тохирох асуудлууд гээд ер нь бүгдийг л иж бүрнээр нь оруулахаар орж ирж байгаа юм, цуваад орж ирнэ.

Энэ малгай хууль буюу гол эдийн засгийн эрх чөлөөгөө бид тунхаглаж, бидний барих гол зарчим энэ. Дараа, дараа ерөөсөө энийгээ л барина. Энэ гол манлайлж байна. Жишээлбэл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал гээд Үндсэн хууль батлагдангуут дагаж Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал гэж баталдаг. Үзэл баримтлалаа батлангуут гадаад бодлого, батлан хамгаалах

номлолоо, цэргийн номлолоо өөрчлөөд баталдаг гэх мэтийн энэ бизнесийн үндсэн суурь зарчмынхаа хуулийг бид гаргаад авахад, дагаад энэ зохицуулалт хийж байгаа 200 гаруй хуулиудад тусгалаа олоод л өөрчлөлтүүд ороод, ингээд Засгаас өргөн барьж байгаа энэ олон хуулиуд чинь дагаад ороод ирнэ. Ер нь энэ жил энэ хаврын чуулгандаа багтаад энэ эдийн засагтай холбоотой энэ бодлогын реформын асуудлуудаа, энэ эрх зүйн орчны өөрчлөгдөх асуудлуудаа нэг хийе гэж байгаа юм. Тэгээд энэ дээр бүх л улс төрийн намуудтай хамтран ажиллахыг хүсэж байгаа. Энэ бол Их Хурлын, энэ бидний, та бидний энд 4 жилийн их том ажил болох болов уу л гэж найдаж байна. Тэгээд 27 оноос улс төржөөд ажил хийцгээхгүй байлгүй дээ гэж бодож байна шүү дээ.

Нийгмийн зайлшгүй хэрэгцээ гээд, нийтийн эрх ашиг гээд л зөндөө тодорхойлолт байгаа, онц байдлын үе, онцгой байдлын үе, дайн бүхий байдлын үе гээд л, гамшгийн үе гээд л олон зүйл болдог. Тэр үе тэрийг л багцалж хэлж байгаа зүйлүүд шүү дээ. Тайлбаруудын нэр томъёолол дээр сайхан тайлбарлаад өгнө. Жишээлбэл гал түймэр гараад, түймрийн аюул болоход яаралтай ААН-үүдийг дайчлаад, гал унтраахад дайчилдаг, үер ус боллоо ААН-үүдийн машин тэрэг, туулах чадвартай машин тэргийг дайчилдаг, дайн бүхий байдал болбол энд байгаа бүх машин техник, хүнсний нөөцөөс авхуулаад олон зүйлийг дайчилна. Тэр нийтийн эрх ашиг гэж байгаа. Нэг талдаа бизнесийн эрх чөлөөг хамгаалах, нөгөө талдаа хэрэглэгч буюу иргэдийн эрх ашгийг хамгаалах энэ 2 зохицуулалт л байгаа юм. Тэгэхээр энэ нийт нийгэм гэсэн энэ ерөнхий нэр томъёог нарийвчлах, бүр дотор нь задлах асуудлыг бүгдээрээ ажлын хэсэг байгуулах тэр хэлэлцүүлгийн явцдаа сайхан оруулаад, тэгээд бүр тодорхой ойлгочихмоор байгаа юм.

Дайн болоогүй, гамшиг болоогүй, онц байдал тохиолдоогүй үед та тэгэхгүй гэдэг буюу хувийн хэвшлийнхээ нөгөө хамгаалалтаар. Тэгэхгүй бол бас захиргааны журмаар янз янзын эрх хэмжээ хэтрүүлэх юм үүсэх тийм эрсдэл байна. Таны болгоомжлолтой санал нийлж байгаа. Тэрийг нарийн томъёолоод ингээд явахад хаана хаанаа ойлгогдоод л явчихна.

Р.Сэддорж: Лодойсамбуу гишүүн тодруулж асууя.

Ж.Энхбаяр: Тэр 200 хуулийг.../минут дуусав/

Ч.Лодойсамбуу: 200 хуулийг хэрэгжүүлэхдээ энэ зарчмыг баримтална гээд. Үндсэндээ манай Энхбаяр сайд бол асуудлаа яг мэдээд, ойлгоод байгаа юм л даа. Тэгээд уг нь энэ нэг хуулиар биш, энүүгээр тогтоосон зүг чигтээ тааруулаад бид ингээд зохицуулалттай явна гээд энийгээ мэдээд байгаа юм. Тэгэхдээ заавал энэ хуулийг батлах гээд байгаагийн үндсэн зорилго нь би тэр нэг бизнесийн зөвлөл гээд байгаад л юм болов уу даа, тэрийгээ л нэг хуульчилж авах гээд байгаа юм болов уу даа л гэж хардаж байна. Тийм.

Энэ өнгөрсөн өмнөх Ерөнхий сайд нэг бизнесийн зөвлөл гэж нэг юм байгуулаад, баахан компаниудыг дэргэдээ суулгаад, тэгээд тэнд нь ирэхгүй бол нэг дарамтлах маягтай нэг ийм юм яасныг одоо хуульчилж аваад, тэгээд тэр нэг бизнесүүд нь тэнд нь очихгүй бол бас болохгүй нэг ийм нөхцөл байдал бий болгоод л, энийгээ баталж авах гээд байгаа юм болов уу. Өөрөөр бол энэ нэг их ийм онцгой хэрэгтэй шаардлагатай юм ерөөсөө энд харагдахгүй л байгаад байх юм. Тэгээд энэ эдийн засагчид намайг бодвол сайн мэдэж байгаа байлгүй дээ. Энэ эдийн засгийн эрх чөлөө ингээд нэг цаасаар явчихдаггүйг. Тэгээд та тэр бодлогын зөвлөл билүү юу билээ.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Бизнесийн энэ зөвлөл бол бизнес эрхлэгчдийн, баялаг бүтээгчдийн статусыг нь жоохон өндөр болгоод, төрд тэр үг хоолойгоо хэлдэг, тэр гарч байгаа хууль тогтоомжид саналаа хэлдэг, заавал тэнд нь оролцоог нь хангах ийм л зүйл. Үнэхээр манай залуу гишүүд энэ дээр их эмзэглээд, хэрэггүй гээд байвал хэрэггүй гээд л аваад болно шүү дээ. Уул нь энэ хэрэгтэй гэж би ойлгоод байгаа байхгүй юу. Аливаа улс төрийн сонгуульд ялсан намын дарга тэр Ерөнхий сайд кабинетаа удирдахдаа л бизнесийнхээ дуу хоолойг сонсдог ийм зарчимтай л болчихвол, энэнээс болоод нэг буруудах юм алга, сөрөг юм алга. Энэ уул нь их чухал хэрэгтэй гэж би ойлгож байгаа байхгүй юу даа. Тийм. Өмнө нь бол зүгээр хэлбэр л яваад байсан юм. Одоо жоохон статус нь өргөөд, та заавал энийг сонсоно шүү гэдгийг л тэр улс төрчдөд нэг дохиуртай болгоод өгнө шүү дээ, та заавал бизнесийн саналыг сонс, та бол заавал.../минут дуусав/

Р.Сэддорж: Лодойсамбуу гишүүн 1 минут.

Ч.Лодойсамбуу: Манайд чинь энэ тоон статистик мэдээллээ гаргадаг төрийн байгууллага нь байж байна, Эдийн засгийн хөгжлийн яам нь байж байна, Хувийн хэвшлүүд нь нийлээд танхим байгуулчихсан байж байна. Тэгээд заавал нэг хэдэн компани тойруулж суулгаж байж юм яривал энэ хэдээр яадаг юм бэ? Тоогоо харж байгаад дүгнэлтээ гаргаад, энэ нэг ийм заавал хоорондоо нэг уулзаад, тэгвэл, ингэвэл яадаг юм хө гэж ярьдаг байдлаар энэ ажилладгийг хуульчилж яах гээд байгаа юм бэ л гээд байгаа шүү дээ. Энэ тоо, статистик, дата мэдээллүүд нь байна. Тэрэн дээрээ анализ, дүгнэлтүүдээ хийгээд, бодлогын шийдвэрүүдээ гаргаад явдаг энэ бүтэн механизм нь ажиллаж байгаагийн нэг нь өөрөө та шүү дээ.

Жишээлбэл хамгийн наад захын эдийн засгийн эрх чөлөө гэдэг чинь хот нь такси компани байгуулах гээд, хот нь таксины компаниудад зээл өгөх гээд, 2000 машин оруулж ирнэ, 2 ээлжээр жолооч ажиллуулна гэж хэлэхгүй байхыг л эдийн засгийн эрх чөлөө гээд байгаа шүү дээ. Заавал энэ цаастай, цаасгүй тэр хотын даргадаа хэлчихэд л эдийн засгийн эрх чөлөө хангагдчих гээд байгаа юм шүү дээ.

Р.Сэддорж: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Лодойсамбуу гишүүнээ яг наадах чинь л манай энэ дарга нарт байхгүй байгаа байхгүй юу, ойлгож байна уу? Энэ хязгаарлачихсан зохицуулалтууд байхгүй байгаа байхгүй юу. Байхгүй ээ, байхгүй байгаа байхгүй юу даа. Та олоодох, байхгүй. Тийм болохоор төр хувийн хэвшлийн хийж байгаа үйл ажиллагаанд оролцохыг хатуу хориглоно гэж энүүгээр чинь хязгаарлалтууд хийж өгч байгаа байхгүй юу. Хязгаарлах хэрэгтэй байгаа юм. Төрийн албан хаагч ийм юманд оролцож болохгүй, төр ийм юманд орж болохгүй. Энэ чинь тэр зохицуулалт их хатуу шүү дээ. Төрөө нэлээн хязгаарлаж байгаа. Энэ хязгаарлалтууд байхгүй болохоор сайн сайхны төлөө гээд тэр такси бааз байгуулна уу, бусад нийтийн бизнесийн хийх орон зай руу төр ороод байгаа байхгүй юу. Өнөөдөр эдийн засаг дахь төрийн өмчит компаниудын оролцоо өндөр болчихоод байна шүү дээ. Энэ нь өөрөө эдийн засгийг боомилоод байна, хувийн хэвшлийнхээ өсөх, тэлэх орон зайг хаагаад байна. Иймд төрийн оролцох олон зүйлийг хааж өгье, багасгая, төрийн өмчийн компани.../минут дуусав/

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан.

Л.Энх-Амгалан: Гишүүдээ юу яая, би гишүүдтэй адил байр суурьтай байгаа юм. Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдсаны гол зорилго энэ төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалтын бодлого, орчныг сайжруулах чиглэл рүү том тогтолцооны шинэчлэл хий л гэж бид энэ яамыг байгуулсан шүү дээ. Тэгээд яах вэ энэ яамны оруулж ирж байгаа Эдийн засгийн эрх чөлөөг дэмжих тухай хуулийг би энэ Их Хурал дээр хэлэлцэгдэж эхлэх гэж байгаа Баялаг бүтээгчдийг дэмжих тухай багц хуулийн нэг хууль л гэж ойлгоод байгаа шүү дээ, малгай хууль тийм ээ. Малгай хууль, суурь хууль нь бол Үндсэн хууль л даа.

Тэгээд мэдээж энэ Эдийн засгийн эрх чөлөөг дэмжих тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Төрийн өмчийг өөрчлөн зохион байгуулах тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төлбөрийн чадваргүйдлийн дампуурлын тухай хуулиуд гээд энийгээ нэг цогцоор нь ярих ёстой гэж ойлгож байна 1 дүгээрт.

2 дугаар асуудал энэ гишүүдтэй би адилхан нэг байр суурьтай байгаа юм Энхбаяр сайдаа. Нэгэнт ингээд яам яг энэ бодлогоо барьж байгаа, хөрөнгө оруулалтын орчноо яах бодлого сайжруулахын яам учраас энэ 200 гаруй хүчин төгөлдөр байгаа энэ хууль тогтоомж сая Лодойсамбуу гишүүн ч хэлээд байна шүү дээ. Энэ дээрээ нэг анализ хийгээд, хийчихсэн анализууд нь байгаа ч байх. Аль нь чөдөр тушаа болоод, аль нь юу болоод байгаа юм, дэмжээд байгаа юм, аль нь боомилоод байгаа юм гэдгээ нэг ойлгомжтой болгоод энийгээ нэг арилгаж чадвал энэ хууль батлагдсанаас ч илүү их тийм бизнесийнхний нурууг авсан энэ хүнд суртлаас бид салчих болов уу гэсэн нэг ийм ойлголтууд байгаа юм.

Өнөөдөр манай Монгол Улс шиг бүх гаднын хөрөнгө оруулагч нартайгаа ийм маргаанд орчихсон, хэрүүл маргаантай болчихсон, тэр нь олон улсын арбитрын шүүх дээр оччихсон, эхнээсээ тэр Хан ресурс гээд та хэлж байна 70 сая долларын бид Монгол Улсын төрийн татвар төлөгчдийн мөнгө шүү дээ 70 сая доллар шүү дээ. Өнөөдөр Эрдэнэт компани тэр Стандарт банканд 120 сая доллар төлөх шийдвэр нь гарчихсан, 40 сая долларыг нь төлөөд явж байна гэх мэтчилэнгээр ингээд Оюу толгойтойгоо 300 хэдэн сая долларын маргаанд орчихсон, Петрочайнатайгаа татварын маргаанд орчихсон ийм л улс орон болчихоод байгаа шүү дээ бид чинь, хөмөрсөн тогоо шиг гэдэг шиг. Тэгээд их тийм том, том юм ярина, том, том юм хүснэ. Одоо нэг жаахан ажил хийж, хийхгүй бол ингээд бидэнд хуулийн Монгол Улсад би ер нь хууль цөөдөөгүй гэж ойлгоод байгаа шүү дээ 400 гаруй, 470 гаруй хууль байна. Хууль нь хэрэгждэггүй, хууль нь амилдаггүй. Нэг хууль нь нөгөө хуулиа боомилсон нэг ийм л хуулийн нөгөө чөтгөрийн тойрог гэдэг шиг хуулийн тойрогт орчихсон ийм л улс орон болчихсон шүү дээ.

Тэгээд энэ дээрээ бид их үнэлэлт, дүгнэлт хийж, их зөв алхам хийж, хэрэв шийдэл хийж чадвал тогтолцооны шинэчлэл хийе л дээ. Татварын шинэчлэл, энэ хяналт шалгалтын шинэчлэлүүд, ингээд мэдээж зөвшөөрлийн энэ томоохон тогтолцооны шинэчлэлүүд эхлэх гэж байна гэх мэтчилнээр бид нэг ийм системийн зөв шинжилгээ хийж байж, нөгөө зовлонгийн шалтгаанаа зөв тодорхойлж байж, шийдлүүдээ олохгүй бол ингээд тойрч ярьж, нэг ийм илсэн, нэг косметикийн шинж чанартай гал унтраасан маягийн нэг ийм хандлагаар хандах шаардлагагүй л гэж би бодож байгаа юм. Тэгэхээр энэ нэг хуулиудыг.../минут дуусав/

Р.Сэддорж: Энх-Амгалан гишүүн нэг минут авах уу? Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

П.Сайнзориг: Би Энх-Амгалан гишүүнийг дэмжиж байна. Яг л ийм байр суурьтай байгаа. Яах вэ эдийн засгийн хөгжлийн сайд асуудлыг зөв оношилчихоод байгаа юм. Шийдэл дээрээ арын баг маань залхуурсан байна. Улсын Их Хуралд өргөн барих хууль тогтоомж иж бүрэн орж ирэх ёстой. Түүнээс биш энд та нар гүйцээчих, та нар ярих сэдэвтэй байх ёстой гээд Дэгийн хууль өөрчлөгдсөн байгаа. Улсын Их Хурал Засгийн газрын өргөн баригдаагүй буюу хууль санаачлагчийн өргөн баригдаагүй ямар ч хуулийн төслийг хэлэлцэх боломжгүй ийм байгаа.

Тэгэхээр энэ дээр миний хэлэх гээд байгаа зүйл юу гэдэг бол иж бүрэн зүйлүүд байсан бол илүү их бүтээмжтэй байх байсан юм болов уу гэж бодож байгаа. Тэгэхээр яах вэ 92 оны Үндсэн хуулиар баталгаажуулсан зүйлийг одоо баталгаажуулах гэж байгаа гэж арай ч үзэл санааны хувьд ухарч болохгүй. Эдийн засгийн эрх чөлөөгүй бол бид хэд энийг авчрах тухай ярьж болно. Эдийн засаг муудсан, эдийн засгийн эрх чөлөө хумигдаж байгаа бол энийг яаж сэргээх вэ, буцааж тэрийг нээх вэ гэдэг асуудлыг цогцоор нь шийдэх ёстой. Тэгэхээр яах вэ энэ хууль маань энэ дээр хэр дорвитой шийдэл болж өгөх юм болов уу гэдэг дээр би жоохон эргэлзээд байгаа юм. Эдийн засаг гэдэг том ойлголт. Энэ өрхийн амьжиргаа, өрхийн орлого, иргэн хүний орлоготой ч хамаатай. Энэ цэвэр ингээд хараад байхаар зүгээр бизнесийн асуудлууд буюу бизнес хийх, аж ахуй эрхлэх, бизнес эрхлэх энэ үзэл санааг л дэмжье гэсэн санаа байгаад байх шиг байна.

Бусад оронд ийм хуулиуд байдаг. Бизнес эрхлэхийг дэмжих тухай хууль, туслах тухай хууль, эдийн засгийн энэ хүнд нөхцөлүүд дээр эдийн засгийг эрчимжүүлж тэлэх тухай хууль гээд Сингапур энэ тэрд байна. Яг энэ зөвлөлүүд байдаг. Тэгэхдээ зөвлөл нь ийм зөвлөлдөх гэхээсээ илүүтэйгээр төрийн ч байгууллага биш, хувийн ч байгууллага биш, илүү их шийдвэр гаргах мандаттай байдаг. Газрын асуудлыг шийддэг, энэ хөрөнгө оруулалтыг орж ирэхэд ийм хэмжээний татварын хөнгөлөлтийг үзүүлэх бололцоо байна гэж шийддэг байхгүй юу. Манайх шиг ингээд 50 компанийн захирал суучхаад, өөрсдөдөө давуу тал олоод, тэгээд энэ дээрээ их дургүй суудаг юм тэд нар чинь. Тэгэхээр чинь ийм зүйлүүд мандатгүй, дүр эсгэсэн, улс төрийн шийдвэр гаргаж байгаа хүмүүсийн хажууд бизнесийнхэн бөөнөөрөө байгаа юм байна гэж л харуулах гээд байдаг байхгүй юу. Тэгэхдээ эцсийн дүнд юу ч шийддэггүй, шийдсэн юм нэг ч хэрэг ч байхгүй.

Тэгэхээр энийг магадгүй яг хуулах гэж байгаа бол Сингапур, Бруней шиг авах ёстой. Бруней жишээ нь энийг татсан шүү дээ, яг мандатыг нь олгосон байхгүй юу. Тэгэхээр би энийг зүгээр яах вэ анхаарах ёстой юм болов уу. Энхбаяр гишүүний сайдын хэлж байгаа шиг хасах биш, энийг харин зөв механизмд ажиллуулж болох уу, үгүй юу гэдэг зүйл байна. Нэг талдаа ингээд төр өөрөө цэгцрэх хөдөлгөөн байгаа боловч, хувийн хэвшил бас цэгцрэхийг асуудлаа дагаад цэгцрэх ёстой юм. Төр, хувийн хэвшилтэй механизм зөвшилцөх механизм мөн байгаа юм Хууль тогтоомжийн хууль, Захиргааны ерөнхий хуулиар гарч байгаа шийдвэр болгон дээрээ. Гэтэл хувийн хэвшлийн хэнтэй зөвшилцөх нь төрд ойлгомжгүй байгаа байхгүй юу. Танхим ерөөсөө тав, зургаахан мянган гишүүнтэй, мэргэжлийн холбоо гээд цүнх баригчтай.

Ийм байгаад байгаа учраас хувийн хэвшилтэй зөвшилцөхөд хүнд байгаа учраас Танхимын хуулиасаа эхлээд шинэчлэгдэх ёстой. Ингээд яг албан ёсны бизнесийн нийтлэг эрх ашиг ярьдаг болохгүй бол, танхимын нэрээр орж ирэнгүүтээ хувийн бизнесээ яриад суудаг захирлууд манайд байна.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Тэгэхээр би энэ хуулийн нэрээсээ эхлээд бизнесийн орчны л тал руугаа жоохон явъя, тэгээд гол шийдэл болоод байгаа Энхбаяр сайдын өөрийнх нь хэлээд байгаа энэ хуулиудыг зарлачихмаар байна сайдаа. Энэ, энэ хуулиудыг бид яг энэ хууль, малгай хуулийн дараа шинэчилнэ, энэ бол бизнесийн чөдөр гээд зарлачихъя. Тэр чөдрийг асуудал хариуцсан яам, сайд нь засах хугацааг нь та Шадар сайдын хувьд өг. Тэгээд өргөн барьж орж хэлэлцүүлж чадахгүй бол энэ дээр нь ёстой хариуцлага тооцмоор байна. Жишээ нь тэр яриад байгаа Ашигт малтмалын хууль, Эрчим хүчний хууль, Татварын хууль, бизнесээс гарч байгаа тэр маргааныг нь шийддэг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх Хууль зүйн сайдын хууль, Шүүхийн шийдвэрийн хууль, өөр юу гэдэг юм Оюуны өмчийн хууль, Хөдөлмөрийн хууль. Яагаад ажилтнуудаа бид илүү их хамгаалдаг шигээ ажил олгогчоо ингээд дандаа үзэн ядаж, бизнес хийж байгаа, мөнгө олж байгаа хүмүүсээ ингээд асуудлыг тариад байгаа байхгүй юу. Тэгээд төрийн энэ эс үйлдэхүй болсон энэ хандлагыг яаж өөрчлөх вэ буюу магадгүй тэр Авлигын хуулийн 22.1 байгаа шүү дээ, одоо ер нь төрд төрийн өмчит компани дээр шийдвэр гаргаад явахаар 3 үсэгтэй газар дуудаж байгаа учраас ерөөсөө юунд ч очихоо болилоо. Тэгээд бизнестээ улам.../минут дуусав/

Р.Сэддорж: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Тэгэхээр энэ ерөөсөө л өнгөрсөн Монгол Улсын 35 жилийн амьдралыг зохицуулж байсан бүх хуулийг л бид эргэж харах юм. Энэ эрх зүйн их том реформын ажил, маш том. Тэр 200 хууль, зөвхөн гадна зориулсан 40 хуулийн зохицуулалт яваад байна шүү дээ. Тэгээд үр дүн бид яагаад арбитрт Монгол Улс ингээд сая, сая доллар төлөөд байна, яагаад эдийн засаг дахь төрийн оролцоо хэтрээд, төрийн өмчийн компаниуд нэмэгдээд байна, яагаад бизнесийн орон зай хумигдаад байна, яагаад гадаадын хөрөнгө оруулалт Монголд орж ирэхгүй байна, тэгэхээр бид хөдлөх хэрэгтэй гэсэн үг шүү дээ. Тэгэхээрээ эхлээд тугаа босгох хэрэгтэй. Монгол Улсын бизнесийн туг бол зарчим энэ, дүрэм энэ. Энд нийцүүлээд бусад тэр процессын салбарын хуулиудаа бүгдээрээ ингээд барьж аваад хийцгээе.

Засгийн газраас татварын багц хууль, хяналт шалгалтын тэр зохицуулалтын асуудлууд, тэр худалдааны хуулиуд энийгээ оруулж ирнэ. Бид үүрэг авсан, ажиллаж байна. Тэгэхээр их өргөн хүрээний юмыг энд бидэнд яг тэр үнэт зүйлийг нь босгож өгнө. Хэвлэлийн эрх чөлөө гэдэг шиг, үг хэлэх эрх чөлөө гэдэг шиг, өмчийн халдашгүй байдал, төрийн эдийн засаг дахь оролцоо эд нарыг нь хатуу хаах боох юмаа нэг дүрмээ, замын дүрмийг л бид шинэчилж гаргаж байна гэсэн үг шүү дээ, бизнесийн дүрмийг. Энд төр орно, энэнээс цааш болохгүй. Орвол зөвхөн ийм, ийм хатуу шаардлага. Ийм үндсэн үнэт зүйл, зарчмыг нь гаргаад ирэхээр энд нийцээд аяндаа бусад тэр зохицуулалтууд чинь тэндээ нийцээд, нийцээд ирнэ. Энэ нь яг тодорхой нөгөө бизнес, эдийн засгаа дэмжсэн ийм үндсэн зарчмуудаа бид хуульчилж өгөөгүй, ийм зохицуулалтын хууль байхгүй явж ирсэн. Тэрний үр дагавар чинь энэ олон нөгөө хүнд суртлууд, чирэгдлүүд, нөгөө авлигууд, нөгөө хөрөнгө оруулалт энэ маргаан, хөрөнгө оруулалт, эдийн засгийн өнөөгийн байдал чинь үүсээд байна гэж үзэж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ 200 гаруй хууль, энэ чинь Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдаад л хийсэн ажлууд. Тэгэхээр энэ хэлэлцүүлгийн явцад бид та нарт мэдээллээр хангаад ингээд яваад байна. Манай Байнгын хороо Эдийн засгийн байнгын хорооныхон энэ дээр их хамтраад ороход энэ их олон зүйлийг хийж болно. Энийг нэг хамтраад энэ 26 оны том ажил болгоод, ер нь бизнесийн орчныг нэг

сайжруулъя. Энэ парламент Монголын бизнесийн орчин, хувийн хэвшлийг бид ингэж дэмжлээ. Төр, эдийн засгийн түншлэлийн асуудал ингэж шийдлээ, ингэдэг, зөвлөдөг механизмтай боллоо, гаднын хөрөнгө оруулалтын ийм таатай орчныг бүрдүүллээ гэдгээ нэг ард нь гарахад үнэхээр их дэндүү олон өргөн хүрээний ажил шүү дээ. Тэгэхээр үндсэн зарчмыг нь л гаргаадахъя. Энд нэг дараа нь орж ирж байгаа бүх юм энд нийцнэ л гэдэг зарчим.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн нэг минут.

П.Сайнзориг: Би сайдын зовлонг ойлгоод байгаа юм. Тэгэхээр хэдүүлээ нэг ингэмээр байна. Нөгөө юманд таалагдахын тулд баахан юм хэлдэг, тэгэхдээ өгөх юмгүй, шийдэх юмгүй болбол баахан хүлээлт л үүсгэнэ. Тийм учраас энийг бодитой болгохын тулд таны ярьж байгаа энэ зарчмуудыг хэрэгжүүлэх тэр арга замууд дээр нэлээн детальчилж өгч болж байна. Энэ процессын шинжтэй болгож өгөх ёстой, энэ зарчмын ард ямар процессууд байх вэ? Тэрнээс агуулгыг бүгд ойлгож байгаа Үндсэн хуулиар заачихсан байхгүй юу.

2 дугаарт бид хэдийн нэг хандлага байгаа, манай хууль зүйн систем үнэхээр ерөнхий явж ирсэн, энийг би хүлээн зөвшөөрнө. 2017 оноос хойш хандлага жоохон өөрчлөгдөж байгаа юм. Захиргааны хууль, Хууль тогтоомжийн хуулийг хэрэгжүүлэх асуудал буюу хуулиар эрх олгосны хүрээнд дүрэм журам гаргах гэж одоо оролдож байгаа юм. Хуучин яадаг байсан бэ гэхээр ерөнхий тавхан өгүүлбэртэй хууль хийчхээд, сайдууд нь дураараа баахан дүрэм журам гаргадаг байсан. Одоо ингээд хумих гээд л, хумих гээд явж байгаа тэр процессын дүрэм журмуудыг чинь хуульд нь шингээж өгөх асуудал одоо ингээд дараагийн давлагаа хүлээгдээд байгаа байхгүй юу. Энийг хийгээсэй гэж хүсэж байгаа юм.

2 дугаарт хамгийн сүүлийн санал би Энхбаяр сайдыг энийг тэр чөдөр болсон хуулиудыг зарлаад, яг өөрчлөх хугацаатай зарла.../минут дуусав/

Р.Сэддорж: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Нийгэм маань байнга л дэвшиж өөрчлөгдөж, бид хөгжлийн өнөөгийн түвшинд ирчхээд байна шүү дээ. Дахин шинэ шатад гарахын тулд эрх зүйн орчноо жоохон боловсронгуй болгоно. Тэгэхийн тулд замын хөдөлгөөний дүрмээ их тодорхой болгоё л гэсэн, бизнесийн дүрмээ тодорхой болгоё. Энд бусад замын хөдөлгөөнд оролцогчид оролцоод явахад ойлгомжтой байна. Асуудал үүсвэл, хэрэг маргаан гарвал яаж шийдэхийг нь тодорхой болгоё гэсэн зарчим шүү дээ. Тэрнээс шууд ингээд үгүйсгээд, чөдөр гэхээсээ илүү ер нь энэ 200 гаруй бизнесийн харилцааг зохицуулж байгаа хууль дүрмүүдийг бүгдийг нь нэг цогцоор нь эргэж харах цаг болсон. Энэ бол өөрөө их урт хугацааны процесс. Нөгөө хуулийн, 200 хууль гээд та нар бод доо. Бид 2 жил болж байна, хэдэн хуулийн ард гараад байгаа билээ парламент өнөөдөр. Одоо бидэнд 2 жил байна, 2 жил дотор бид ингээд яахад бүх шат дамжлагаа зохицуулалтаа ингээд аваад явахад.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут нэмж өгье Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Зөвхөн яг энэ бизнес зохицуулж байгаа 200 гаруй хууль тогтоомжид өөрчлөлт хийх асуудал гэдэг чинь том ажил шүү дээ. Тэгэхээр энийг хийе гээд зорьж байгаа, ярьж байгаа нь их сайн байна, зайлшгүй юм байгаа юм. Эхлээд суурь бодлогыг нь гаргаадахъя, зарчмыг нь гаргаадахъя. Тэгээд тэр зарчимдаа нийцүүлээд наад 200 хууль дээрээ ажиллая л даа. Хувааж аваад, ажлын

хэсэг байгуулаад тав таваараа, та нар энэ салбарын 5 хууль, энэ 5 гэж хувааж аваад, тэгээд тэр зарчим гэдэг буюу суурь юман дээр чинь л тэрийг чинь босгож өгөх гээд байхгүй юу тугийг чинь энд л очно гэж. Тэгэхгүй бол ахиад салбар, салбарын эрх ашиг, орон нутгийн нөлөөллийн юм чинь орж ирээд өөр, өөр болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд л нөгөө давхардсан шалгалтууд, давхардсан зохицуулалтууд, давхардсан хяналт шалгалт, дүрэм журам, зөвшөөрөл чинь ихэдчихээд байгаа нь тэр. Тэгэхээр зарчмыг нь заавал босгож, тунг нь босгож өгдөг. Тугийг нь босгож өгөөд, тэнд бүх юмыг нь нийцүүлэх ажлыг хийе гэвэл хийхэд бэлэн байна шүү дээ. Тэгээд хийгээд л явцгаая бүгдээрээ. Тэгэхгүй бол эхний нөгөө тугаа зорилгоо гаргах гэхээр.../минут дуусав/

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Сайнзориг гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Анар.

Ч.Анар: Энхбаяр сайд агуулга, зарчмыг нь та одоо асуудлаа харчихсан дэмжиж байгааг нь хараад байгаа, бид дэмжээд байгаа юм. Тэгэхдээ түрүүн Сайнзориг гишүүн хэллээ л дээ. Нөгөө том та энэ чинь аягүй том реформын шинж чанартай хууль гээд байна. Тэгсэн мөртөө яагаад ийм нимгэхэн байгаа юм бэ? Ийм том реформ гэхээр чинь би ерөөсөө ойлгохгүй. Тэгээд нөгөө Засаг бас ийм юм сурчихсан нөгөө хийх судалгаануудаа зүгээр ингээд боловсруулж оруулж ирэнгүүтээ нэг хэдэн хэнээтэй гишүүд байдаг юм гээд биднийг, одоо тэгээд сая бид чинь яг энийг аятайхан болгох гээд 200 хэдэн хууль дээр чинь бид суух болчихлоо шүү дээ.

Тэгэхээр би бол яг энэ хуулийг хэлэлцэхийг нь дэмжиж байна. Тэгэхдээ Засаг бүрэн бүрэлдэхүүнээрээ таныг бол тунхаг туг зоох гэж байгааг нь ойлгож байна. Гэхдээ нөгөө дахиад 200 хууль дээрээ энэ нь ийм асуудалтай байна, энэ нь чөдөр тушаа болоод байгаа юм байна гэдэг хуулийн дүгнэлтүүдийг нь нөгөө Засаг чинь өөрөө тэрийгээ бүүр сайн мэдэж байгаа шүү дээ, гаргаж ирээд оруулж ирэхгүй байсан юм уу л гээд. Тэгэхээр логик нь аягүй зөрөөд байгаа юм биш үү? Тэрийгээ шинэчилчхээд орж ирэх ёстой юм уу? Тийм. Би одоо ажлын хэсэгт ороод дэмжээд оръё гэхихсэн чинь баахан 200 хууль дээр ажиллах болчих гээд байна шүү дээ. Тийм. Тэгэхээр Энхбаяр сайд та би ерөөсөө таны ярианаас нэг юм ерөөсөө ойлгосонгүй. Та 200 хуулийг өөрчилье гээд байгаа юм уу, ерөөсөө өөрчлөхгүй гээд байгаа юм уу, тэрийг нь ерөөсөө ойлгогдохгүй байна. Тэгэхээр энэ дээрээ яг тодорхой болгоод, энэ хууль бол явах ёстой, магадгүй яг тэр Сайнзориг гишүүний хэлсэн энэ нээрээ магадгүй Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийг гэсэн үндсэн агуулгын хувьд жоохон эргэлзээ байна. Тэгэхээр хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, тэгээд хамтраад ард нь гаръя даа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу.

Ч.Лодойсамбуу: Энэ Энхбаяр сайдаа энэ бүх гишүүд санал нэгдээд байна шүү дээ. Ер нь зарчмын хувьд наад тунхаг чинь бол Үндсэн хуулиараа байгаа, бид нэг л юмаа бодож байна. Тэгэхдээ бид ингээд орж ирчхээд тэгэхдээ энэ бид энэ Засгийн газраар ажлыг нь хийлгэх хэрэгтэй. Энхбаяр сайдад буруу өгч чадахгүй байна, томилогдоод нэг сар болчихсон. Тэгээд манай Монгол Улсын Ерөнхий сайд хэрвээ байгаа бол уг нь Ерөнхий сайдтай байсан бол өнөөдөр энэ асуудал орж ирээд, энэ 6 сарын хугацаанд чинь бүх асуудлууд нь орж ирнэ шүү дээ. Юу ч хийхгүй байна шүү дээ Энхбаяр сайдаа, тийм танаар дамжуулаад би нөгөө нэг манай улсад

байгаа бол тэр Ерөнхий сайдад хэлээд байна л даа. Занданшатар даргыг бол хараад байгаа шүү дээ, байгаад байна лээ. Ерөнхий сайдыг олж харахгүй байна.

Хэрвээ Монгол Улсад Ерөнхий сайд байсан бол өнөөдөр татвар, нийгмийн даатгалын асуудал хамгийн наад зах нь орж ирсэн байх ёстой. Өнөөдөр таны яриад байгаа эдийн засгийн эрх чөлөөний асуудал бүх зохицуулах ёстой 200 хууль чинь засвар хийгээд ороод ирэх ёстой. Одоо энэ дагаад ороод ирчихсэн яамны мэргэжилтэн залуучуудаас бид санаа зовж ичиж байна шүү дээ. Эд нар бүх асуудлуудыг мэдчихсэн, судалчихсан, тогтоочихсон, эд нар ингээд нэг аваад явчхаасай, биднийг дооглоод сууж байгаа шүү дээ. Тэгэхгүй ингээд нэг Эдийн засгийн эрх чөлөөний хууль гээд нэрлэчихсэн тэрийгээ, тэгээд нэг ийм юм оруулж ирчхээд, бас биднийг бол дооглоод л сууж байгаа яг үнэндээ дотроо.

Тэгэхээр Засгийн газар үнэхээр хангалтгүй байна гэж хэлж байгаа юм. Ялангуяа Ерөнхий сайд. Улс төржөөд байгаа юм байхгүй шүү дээ энд чинь. Үнэхээр энэ парламент орж ирээд, энэ гишүүд чинь шинээр орж ирсэн 80 хувь нь шинээр ороод ирчихсэн, жил хагасыг нь өнгөрөөчихсөн, тэгээд хамгийн том хүлээлттэй эдийн засгийн эрх чөлөөг бий болгох, эдийн засгаа тэлэх, өрхийн амьжиргаагаа дээшлүүлэх нэг ч алхам хийхгүй 1 жил 6 сар болж байна. Тэгээд парламент нь бурууг нь аваад сууж байгаа байхгүй юу. Засгийн газар бодлогоо оруулж ирэх ёстой шүү дээ. Гишүүд нь өргөн барихаар баталж өгдөггүй, хэлэлцэж өгдөггүй, Засгийн газар нь өөрсдөө оруулж өгдөггүй, оруулж ирдэггүй. Тэгээд үндсэндээ Засгийн газар нь PR-аа хийдэг, Их Хурал нь Засгийн газрынх нь ажлыг хийдэг болчихлоо шүү дээ. Засгийн газар нь хэзээ ажил хийх юм бэ?

Сая Сайнзориг гишүүн яг хэлж байна шүү дээ Засгийн газар дэндүү залхуурч байна. Эдийн засгийн эрх чөлөөгөө сайжруулъя гэсэн чинь Эдийн засгийн эрх чөлөөний хууль гээд нэг цаас оруулаад ирчихсэн шууд. Тэгээд энийг ингээд өөрчилье гэхээр тэгвэл тэгье ажлын хэсэг байгуулаад та нар өөрчлөөд өгөөч. Нөгөө талдаа нөгөөдүүл нь нэг ийм PR-аа хийгээд л, ажлыг нь Их Хурал хийдэг боллоо. Ер нь Монгол Улсын Засгийн газар инкубатор төв боллоо. Ерөнхий сайдынх нь суудал нь Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн инкубатор, дэд сайдынх нь суудал нь Их Хуралд горилогчдын инкубатор, зүгээр бэлтгэл хийдэг газар болчихлоо шүү дээ. Нүгэл шүү дээ энэ бол. Монгол орны хувь заяагаар сонгуулийн PR хийж байна шүү дээ, энэ бол нүгэл шүү дээ.

Монгол Улсын Ерөнхий сайд залхуудаа биш, ажилсаг хүн, ухаантай хүн. Бид аль эртнээс нэг нэгнийгээ мэднэ. Яагаад хөдлөхгүй байна гэхээр илүү үйлдэл хийхгүй байж байгаад Ерөнхийлөгчийн сонгуульд орох гээд байна. Энийг бүгд мэдэж байгаа, манай Энхбаяр дарга яаж ч үрчийгээд энийг бүгд бүгдээрээ мэдэж байгаа. Хүнд юм яримаар байна, хөнгөн байгаад залхаж байна шүү дээ. Бүтэн жил 6 сар энэ Засгийн газар, Их Хурал чинь хөнгөн байлаа шүү дээ. 6 дугаар сарын 13-нд байгуулагдсан Засгийн газар, та бол яах вэ нэг сар л болж байгаа, хүнтэйгээ ч танилцаж амжаагүй байгаа шүү дээ. Энэ Ерөнхий сайд чинь байгаа бол 6 сарын өмнө томилогдчихсон, эхний 100 хоног дээрээ бодлогоо танилцуулаад, энэ намрын чуулганаар өнөөдөр эдийн засгийн эрх чөлөөг хангах хуулиудаа, татвар, нийгмийн даатгалтай холбоотой хуулиудаа, өрхийн амьжиргаагаа бодсон зохицуулалтуудаа оруулж ирээд батлуулаад сууж байх ёстой байсан юм. Тэрийг л хэлээд байгаа юм. Тэгээд та Ерөнхий сайдтай хэрвээ уулзаж байгаа бол очоод нэг хэлээд өгөөрэй байна уу, байхгүй байна уу. Занданшатар дарга бол энийг сайн ойлгож байгаа. Монгол Улсад Ерөнхий сайд аль Ардын намаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Жаргалан. Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан.

Л.Энх-Амгалан: Бид нэг асуудлыг шийдэх гэж байгаа бол Энхбаяр сайд шийдсэн шиг шийдээд, нэг өргөс авсан юм шиг л асуудалд хандахгүй бол ингээд илээд, эсхүл нэг PR-н хууль, эсхүл нэг косметикийн маягтай юм явж болохгүй гэдэгтэй би гишүүдтэй санал нэг байгаа. Бид зөндөө ярилаа. Тэгээд яг ард иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлаас яг шийдчихсэн шийдлүүдээ бид хэлмээр байна шүү дээ. 7 буудал дээр 8 нэрийн дэлгүүр нээх гээд явж байгаа хүн дээр яг ямар асуудлууд нь тулгамдаад байгаа юм, зовлон нь яг юу байгаа юм. Өнөөдөр 24 мянган аж ахуйн нэгж дансаа хаалгачхаад байж байна татвар дээр. Эд нарын тулгамдсан асуудлууд нь яг юу байгаа юм гэх мэтчилнээр ингээд цөмөөрөө нэг ийм иргэдийн өмнө тулгамдсан асуудалд шийдэл ярьсан, гаргалгаа хийсэн нэг ийм зүйлүүдийг хийхгүй бол ер нь цаг хугацаа нэлээн явлаа, хангалттай их хэрэлдлээ, хангалттай их зодолдлоо. Тийм учраас одоо бодитой нэг ийм шийдлүүдийг гаргая гэж бодож байна.

Тэгээд мэдээж ойлгомжтой манай энэ бизнесийн, Монголын бизнесийн орчны энэ муу жишээ чинь Дэлхийн бизнесийн сургуульд кейс болчихсон байгаа шүү, кэйс болчихсон байгаа Монголын Монголчууд гадаадын хөрөнгө оруулагчтайгаа яаж харьцдаг вэ, гадаадын хөрөнгө оруулагчдыг юу гэж ойлгодог вэ, яаж хохироодог вэ гээд Монгол кейс муу кейс гэдгээр орчихсон байж байгаа. Тэгэхээр энэ бүх зүйлүүд дээр бид нэг тодорхой шийд юу гаргаж, дүгнэлт хийж, тэгээд жишиг байгаа шүү дээ Энхбаяр сайдаа. Одоо бид Зөвшөөрлийн тухай хуулийг өргөн барихад Зөвшөөрлийн тухай хуулийн чинь бараг 110 хэдэн хуулийн заалтуудыг цуцалж байгаа. 110 хэдэн хууль дагаж орж ирж байгаа шүү дээ тийм ээ. Цахимжилтын хуулийг бид хийхэд бараг дахиад 100 хэдэн хуулийг дагуулж оруулж ирж байсан заалтууд.

Тэгэхээр яг өнөөдөр үнэхээр л Бизнесийн эрх чөлөөний тухай хууль энэ бизнесийнхээ орчныг сайжруулах гэж байгаа, төрийн оролцоог багасгах гэж байгаа энэ хууль дээр биччихсэн байгаа гоё зарчмуудыгаа хэрэгжүүлэх гэж байгаа бол, баялаг бүтээгч нарыг дэмжих гэж байгаа бол энэ яг чөдөр тушаа болоод байгаа, энэ боомилоод байгаа энэ бүх хуулийнхаа тэр 200 хуулийнхаа заалт бүрээр нь тэгвэл бид ажиллая л даа. Заалт бүрийг нь бид хүчингүй болгоё л доо. Ингэж байж бид энэ бизнесийн эрх чөлөөний асуудлуудыг ярихгүй бол зүгээр Үндсэн хууль дээр байгаа тунхаглалаа дахиад тунхаглаад оруулаад ирж байгаа юм гээд ингээд яриад байхаар чинь наадах чинь тийм сонсогдохгүй байгаад байгаа байхгүй юу. Сонсогдохгүй байгаад байгаа юм. Яах вэ тунхгийн хууль.

Тэгэхдээ Монгол Улсад өнөөдөр тунхаглалын хууль хэрэггүй шүү дээ. Өнөөдөр Монгол Улс шийдэл гаргасан, асуудлуудыг шийдсэн, ард иргэдийнхээ нуруун дээр байгаа энэ ачаалал, баялаг бүтээгчдийн нуруун дээр байгаа энэ ачааллыг хөнгөвчилсөн, хүнд суртлыг багасгасан, авлигалаа багасгасан, авлигалаа байхгүй болгосон, ар өврийн хаалга нь байхгүй болсон ийм шийдлүүдийг л би цогцоор нь ярьж байж тогтолцооны шинэчлэл гэдэг чинь ийм шинэчлэл байх ёстой биз дээ. Өнөөдөр татварын зүгээр нэг байцаагчийн өнгө үзэмжээс болоод Монгол Улс хэчнээн тэрбумын маргаан дээр очоод зогсож байгаа билээ.

Гаднынхан чинь хэлээд байна шүү дээ. Танай энэ татварын байгууллагын тогтолцоо чинь, энэ маргаан шийдвэрлэж байгаа зарчим чинь болохгүй байна. Энэ хяналт шалгалт хийж байгаа энэ давхардлын тогтолцоо чинь ерөөсөө болохгүй

байна. Шүүх чинь ерөөсөө шударга бус байна, ил тод бус байна. Шүүх дээр очоод энэ бүх маргаанууд чинь хэдэн жил энэ шүүхийн хаалганууд сахиад үлдэж байна. Бүх маргаанууд шүүх дээр, одоо ингээд бизнесийн бүх маргаанууд дандаа шүүх дээр, тэгээд сүүлдээ эрүүждэг, барьж хорьдог. Одоо бид чинь муу жишээ байгаа биз дээ, Саусгоби сэндс-н гаднын захирлыг бид зөвхөн бизнесийн маргаанаас болж хориод, Монголд хорьж байсан тохиолдол байгаа шүү дээ. Энэнээс болж гадаадын хөрөнгө оруулалт багассан шүү дээ, үнэн биз дээ гэх мэтчилнээр ингээд бид өмнө нь байгаа энэ гашуун сургамжууд, энэ олон алдаа дутагдлуудаа зассан, шийдсэн ийм л цогц хуулийн эрх зүйн шинэчлэл, тогтолцооны шинэчлэл байх ёстой л гэж би хараад байгаа юм.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

П.Сайнзориг: Манай энэ парламентын л түүхэн үүрэг байгаасай гэж би зүгээр хүсдэг байсан. Манлайлал үзүүлж ажиллах юм сан гээд бизнесийн орчныг сайжруулах чиглэлд. Тэгээд бизнесийг дэмжих уг нь бүлэг гээд байгуулагдсан юм. Тэгээд тэр бүлэг маань алга болчихсон. Тэгээд би энэ бүлгийг болохгүй бол даанч Эдийн засгийн байнгын хороонд алга, бас нэг гишүүдтэй хамтарч сэргээж санаачилъя гэж бодож байна. Нөхөрсөг хууль гэсэн хэдүүлээ зарчим хөтөлбөрийг гаргая. Яг бизнесийн хууль тогтоомж орж ирвэл улс төржихгүйгээр яг ил яриад, яг энэ нөхөрсөг хуулийн группээс аль, аль талынхаа бизнесийн эрх ашиг, төрийн эрх ашиг, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэйгээр зохицуулах ийм үзэл санаагаар ханддаг байхыг би уриалж байна. Тэгээд хэдүүлээ нам харгалзахгүйгээр нэгдэж болж байна. Ингэж байж бид худалч имижээсээ сална.

Сая Энх-Амгалан сайдын хэлж байгаа үнэн шүү дээ, хэд хэдэн их, дээд сургуулиудын эдийн засгийн хөтөлбөр дээр хамгийн худалч ард түмнээр, хөрөнгө оруулагчдаа хуурдаг ард түмний кейсээр манайх шалгарч байгаа. Хятадыг тойроод ганц хөгжиж чадаагүй ганцхан орноор Монгол Улс шалгарсан. Энэ чинь өөрөө ингээд нэг юм хэлээд байгаа шүү дээ бидэнд. Тэгэхээр энийг өөрчлөх цаг болсон. Тэгээд ерөөсөө ганц л зүйл байна. Бизнесийн чөдөр болсон энэ хууль тогтоомжуудыг зарлая, цаг хугацаатай нь яг засна гэдгээ Засгийн газар, парламент 2 яг зэрэг зарлая. Тэгээд энийгээ хамтарч ажиллая.

Дээрээс нь бизнесийн шийдвэрүүд дээр кабинетын зарчим барьдаггүй сайдуудаа огцруулдаг байя. Нэг нь гараад бизнесийг нухаад л, нэг нь гараад л бизнесийг өмөөрөөд ерөөсөө сүүлдээ энэ учир жанцангаа олдохоо болилоо. Тэгээд ерөөсөө ийм зүйлүүд байгаа учраас л одоо хэцүү байна.

Тэгээд 2 дугаарт ингээд шийдлүүд орж ирэхгүй болохоор хүлээлтүүд үүсээд байна. Тэгээд хэдүүлээ нэг нөгөө нийгэмд таалагдах гэж, тэгээд нийгэмд таалагдахын тулд баахан гоё юм ярьдаг, тэгэхдээ өгөх юм байхгүй, шийдэх санал байхгүй болохоор баахан ингээд л хоосон хүлээлт үүсээд, тэр нь хэзээ нэгэн цагт дандаа итгэл, итгэлцлийн хагарлаар дуусаж байгаа юм. Тэгэхээр ийм зүйлүүд байх юм.

Тэгээд би хамгийн түрүүнд татварын хуулиуд, нийгмийн даатгалын хуулиуд, бизнесээс гардаг дампуурлын хуулиуд, эрчим хүчний хуулиуд, эргээд хөдөлмөрийн хууль тогтоомж, газрын хууль тогтоомж, Хэрэглэгчийн гэрээний хууль, Арилжааны хууль, ингээд оюуны өмчийн хуулиуд, тэр шүүхтэй холбоотой хуулиуд яахад 20-иод багц хууль байгаа юм сууриараа. Энэ 200-гаад хууль л яг бие биетэйгээ уялдахад 25, 6 багц хууль болдог юм. Энийг Хууль зүй, дотоод хэргийн яам дээр би ажиллаж

байхдаа хийж байсан. Тэгээд энэ хууль маань ингээд хувийн эрх зүй, нийтийн эрх зүйг холиод ирж байгаа юм. Би хэт энэ дээр нэг их ганцаараа эрх зүйч юм шиг ингээд онолын юм яримааргүй байна. Тэгэхээр энэ зарчим нь ажиллахгүй сайдаа. Хэдүүлээ энийг жоохон тос усыг нь ялгаруулж байгаад, яг бизнесийн эрх чөлөө, тэн рүү нь чиглүүлсэн төрийн шийдвэр гаргалтыг нь жоохон процессжуулж, жоохон зарчмыг нь тогтоосон хууль болгож анхааръя гэдгийг хүсэж байна.

Тэгээд ерөөсөө бизнесийн чөдөр болсон энэ хуулиудыг Энхбаяр сайд уг нь манлайлал үзүүлээд зарлаад, энийг Хууль зүй, дотоод хэргийн сайд яг.../минут дуусав/

Р.Сэддорж: Би нэг үгээ хэлчихье. Ардчилсан намын гишүүдээс ингээд хуулийн төсөл санаачлаад, бэлдээд, ингээд өргөн барих гэхээр арай процессын нэг зүйл дутагдаад, хэлэлцүүлэг хийгдээгүй гэдэг шалтгаанаар ингээд хүлээж авахгүй байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн нэр нь ч ижилхэн, тэр үзэл санаа, зорилго нь ч ер нь ижилхэн. Тэгэхээр хэдүүлээ энэ хуулийг бол дэмжиж байгаа, миний хувьд дэмжиж байгаа.

Тэгээд бүх л Засгийн газар, яамнууд, Эдийн засгийн яамны үе үеийн сайдууд яг энэ эдийн засгийн эрх чөлөөг яавал сайжруулах вэ, дээшлүүлэх вэ, яавал энэ хорьж цагддаг, энэ зөвшөөрлийг нь хорьдог, шалгадаг, гацаадаг, тэгээд нэг хуушуурын зөвшөөрөл авахад хүртэл аягүй хүндрэлтэй. Тэгээд энэ нийгэмтэйгээ нийцээгүй, нийгмийнхээ хөгжлийнхөө түвшинтэй нийцээгүй ийм хянаж шалгадаг системийг хуульчилчихсан. Гэтэл тэр бүр өндөр хөгжилтэй болчихсон, орлого ихтэй, дотоодын нийт бүтээгдэхүүн нь манайхаас хамаагүй өндөр орнуудад үйлчилдэг энэ хяналтын хуулиудыг манайд ингээд оруулаад ирчихсэн. Тэрийг хэрэгжүүлье гэхээр нөгөө яг нөхцөл байдал нь бүүр яагаа ч үгүй байгаа. Тэгээд ийм эдийн засгийг яаж хэдүүлээ хурдан, богино хугацаанд түрүүлж аятайхан болгох вэ гэдэг дээр бүгд л санаа зовж байгаа.

Энэ гишүүдийн ирүүлсэн энэ авч явж байгаа энэ хуулийг хамтраад хийх хэрэгтэй л дээ. Тэгэхээр энэ чинь, энийг нь хэлэлцүүлэхийг хүлээж авахгүйгээр, Засгийн газраас оруулж ирж байгаа юуг л хүлээж аваад ингээд л явуулаад байна гэдэг бол энэ чинь бид бүгдээрээ л нийлээд батална. Тийм учраас энийг та анхаараад, хүлээж аваад ингээд хуулийн дагуу ажиллацгаая. Энхбаяр сайд, дараа нь Жаргалан гишүүн. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энэ нэр бүхий манай Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан Эдийн засгийн эрх чөлөөний хуулийн төслийг үзсэн. Утга агуулга, зорилго олон зүйл адилхан. Тэгэхээр энэ өргөн барьж байгаа Засгийн газрын хувилбараар хэлэлцэх эсэхээ шийдээд, Их Хурал дээр Их Хурлын даргатай ярьж байгаад чиглэлээ аваад, энэ хуулиудыг хамтраад нэгтгээд хэлэлц гэдэг ийм чиглэлээ аваад, бүгдээрээ цаг алдмааргүй л байгаа юм. Бид мессежээ аль болох нийгэмд түрүүлж хурдан л өгөх хэрэгтэй байна гадаад, дотоод орчиндоо. Цаг хугацаа бидэнд их үнэтэй байгаа. Тэгэхээрээ яг энэ дээрээ нийлүүлээд хэлэлцээд явахад ерөөсөө илүү л үр дүн гарна. Энэ бол дандаа энэ парламентын хамтын бүтээл болох ёстой. Энэ эдийн засгаа тэлсэн, хувийн эрх чөлөөг дэмжсэн, хангасан, ардчиллын суурь зарчмуудаа бид урагшлуулж байгаа зүйл.

Тэгэхээр гишүүдээ энэ процессын болон бусад энэ салбарын хуулиудтай хольж болохгүй. Тэгвэл дуусахгүй ажил буюу Монгол Улсад байгаа бүх энэ 200 гаруй хуулийг эргэж харж өөрчлөлт орно гэдэг бол энэ нүсэр бөгөөд их урт

хугацааны ажил байхгүй юу даа. Тэр талаас нь нэг ойлгоод, гол үндсэн зарчмаа гаргалаа, хуулиа хамтраад хэлэлцүүлээ. Тэгээд энэ зарчимд нийцээд шинэ гарч байгаа бүх хуулиуд, тэгээд энэ байгаа 200 хууль дээрээ бүгд дээр нь дахин update хий гэдэг үүргээ Засагтаа өгөөд, ингээд урт хугацааны бодлого болгоод л бүгдээрээ нэг талаас нь ингээд сайжруулаад явъя.

Үнэхээр бизнесийн орчныг эрс өөрчлөх, эдийн засаг дахь төрийн оролцоо хумих, төрийн албыг эдийн засгийн тэр албан тушаалтны төрийн хэм хэмжээг тодорхой болгохгүй бол тодорхойгүй байдлууд их байгаа болохоор л ийм байдал үүсээд л, тэр маргаан үүсээд л, хөрөнгө оруулалт татраад л, арбитрт Монгол Улс унаад л, эдийн засаг чинь агшаад л байгаа зүйл шүү дээ. Үндсэндээ одоо манай эдийн засаг яг хүчин чадлынхаа яг суурь түвшиндээ ирчихсэн. Ингээд л яг, төмөр зам бүх тултлаа аччихсан, уул уурхайнууд тултлаа ажиллалчихсан, бүх гадаад экспорт, импорт тултлаа хийгдчихсэн. Одоо энэ түвшиндээ 90-ээс 100 их наяд дээр тогтчихоод байна.

Энэ эдийн засгаа бид томруулах хэрэгтэй. Томруулахын тулд хөрөнгө оруулалт татъя, бизнесээ урамшуулъя, хөрөнгө оруулалт, экспортод чиглээ, тэр л өдөөлт суурь нь байхгүй юу, бодлогын суурь. Тэрийг нь хэлэлцээд яваад, ингээд явах ёстой. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн улс төржих юм байхгүй. Гол нь эхэллээ, энэ бололцоог битгий алдаач. Ахиад хаврын чуулган руу хаячихна. Тэгэхээр хаврын чуулганы хэлэлцэх асуудлын төлөвлөгөө гээд зөндөө асуудлууд ороод ирнэ. Тэр талаас нь бодоод ингээд явах ёстой. Энэ бол манай Эдийн засгийн байнгын хорооны энэ үндсэн үүрэг байна шүү дээ, хийх ажил. Тэр үүрэг талаасаа та нар үүргээ ухамсарлаад ингээд нэг хийгээч. Тэгэхгүй бол Засаг тэр Шүүхийн хууль, Эрүүгийн хууль, Иргэний хууль энэ олон процесс хууль дээр бид чинь энийг хийсний дараа наад эдийн засгийнхаа юмыг оруулж ир гэдэг бол аягүй тийм муйхар, зүй бус шаардлага болчихоод байна шүү дээ.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Жаргалан.

Б.Жаргалан: Эдийн засгийн эрх чөлөө гэдэг ардчилсан Монгол Улсын иргэдийн өнгөрсөн 35 жилийн мөрөөдөл зорилго мөн билээ. 1990 оноос хойш Монгол хүн бүр, айл өрх бүр эдийн засгийн эрх чөлөөнд хүрэхийн тулд дор бүрнээ наймаа эрхэлсэн, аж ахуй эрхэлсэн, үйлдвэрлэл эрхэлсэн, компани байгуулсан, шинэ санал санаачилга гаргасан. Бид 35 жил эрвийх дэрвийхээрээ дор бүрнээ хичээж ажилласан. Харамсалтай нь 35 жилийн өндөрлөгөөс эргээд харахад эдийн засаг дахь төрийн оролцоо нь бүүр хэт данхайчихсан, төр нь өөрөө хамгийн том ажил олгогч, төр нь өөрөө хамгийн том татвар төлөгч, ТӨК-уд нь эдийн засгийнхаа тал хувийг эзэлдэг, хувийн хэвшлийн ААН-үүд нь зах зээлээсээ бүрэн шахагдаад гарчихсан ийм нөхцөл байдалтай бид сууж байгаа.

Тэгэхээр энэ нөхцөл байдлаас хэрхэн, яаж гарах вэ гэдэг дээр бид дор бүрнээ санаа бодлоо уралдуулах ёстой. Засгийн газраас Эдийн засгийн эрх чөлөө нэртэй ийм тунхгийн гарчгийн шинж чанартай ийм хууль оруулж ирж байгаа. Эдийн засгийн эрх чөлөө гэдэг ойлголт бол Ардчилсан намын хувьд, Ардчилсан намын үзэл баримтлалын нэгэн хэсэг болсон, Ардчилсан намын суурь үзэл санаа ийм зүйл байгаа юм. Тийм учраас Ардчилсан нам аж ахуй эрхлэгчдээ хамгаалахын тулд, ААН-үүдээ хамгаалахын тулд энэ хуулийг тунхаг биш, үнэхээр эдийн засгийн салбарт өөрчлөлт оруулах, ер нь энэ нийгмийн суурь үзэл санаанд өөрчлөлт оруулах хууль байгаасай гэдэг чиглэлээр зайлшгүй энэ дээр бат зогсох ёстой ийм

ёс суртахууны үүрэгтэй гэж харж байгаа. Яагаад вэ гэхлээр Ардчилсан нам энэний төлөө 35 жилийн туршид тэмцсээр ирсэн.

Харин сүүлийн 10 жилд өнгөрсөн хугацаанд бий болсон энэ алдаа завхралууд, энэ эдийн засаг дахь төрийн оролцоо хэт данхайсан энэ зүйлүүд чинь бий болчихоод байгаа юм. Тиймээс бид энэ асуудалд маш ийм ул суурьтай хандах ёстой. Саяын Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн хэлээд байгаа бизнест чөдөр тушаа болж байгаа хуулиуд нь хаана байгаа юм бэ гэдгийг бизнесийнхэнтэйгээ ил тод, нээлттэй ярилцсаны хүчинд энэ хууль нь цаашаа явах ёстой гэж үзэж байгаа.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн нэр бүхий гишүүдээс Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн бие даасан төслийг боловсруулсан явж байгаа. Тэгээд энэ ташрамд бизнес эрхлэгч, ААН-үүд, ер нь Монголчууддаа хэлэхэд Ардчилсан намтай хамтраад саяын бизнес эрхлэхэд чөдөр тушаа болж байгаа хууль, ямар хууль, эрх зүйн зохицуулалт байна, юун дээр бид өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэдэг дээр энэ 1, 2 дугаар сард хэлэлцүүлгүүд хийгээд, бас энэ хуулийн төслөө чамбайруулаад хаврын чуулганаар хэлэлцье гэсэн ийм саналыг, уриалгыг бизнесүүддээ хэлэх байна.

Тэгээд Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу энэ хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулж, Ардчилсан намын бүлэгт завсарлага өгөхийг хуралдаан даргалагчаас хүсье. Үндэслэл нь юу вэ гэхлээр Эдийн засгийн эрх чөлөөний хууль гэдэг энэ том ач холбогдолтой анхдагч хуулийн төсөл дээр бүлгүүд болон бусад сонирхол бүхий этгээдүүд санал бодлоо нэгтгэж байж, тэгээд илүү ул суурьтай байдлаар асуудлыг авч хэлэх ёстой гэж үзэж байна. Энэ бүлгүүдийн шийдвэр гарсны ар дээр энэ хэлэлцэх эсэх тухай асуудлыг оруулах нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Тэгэхээр завсарлага, 5 хоногийн завсарлага хуралдаан даргалагчаас хүсэж байна.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12.1 дээр энэ хуульд өөрөөр заагаагүй бол нам, эвслийн бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.5-д заасны дагуу завсарлага авах эрхтэй. Завсарлага авах хугацаа ажлын 5-аас илүүгүй өдөр байх бөгөөд шаардлагатай бол нам, эвслийн бүлгийн хүсэлтээр хуралдаан даргалагч завсарлагын хугацааг нэг удаа ажлын 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно. 12.2 дээр нам, эвслийн бүлгийн дарга, түүний эзгүйд дэд дарга энэ хуулийн 12.1-д заасны дагуу завсарлага авахдаа үндэслэл, хугацааг тодорхой хэлж, энэ талаар хуралдааны тэмдэглэлд тусгуулна гэж заасан байна. Ингээд Улсын Их Хурлын гишүүн, Ардчилсан намын бүлгийн дэд дарга Жаргалангийн гаргасан саналын дагуу хуралдаан даргалагчийн зүгээс 5 хоногийн завсарлага өгч байна.

14.11 цаг

Хоёр.Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдсан ажлын хэсгийн явц, үр дүнгийн талаарх танилцуулга

Хэлэлцэх асуудал 2. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэгт Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын үйл явц, үр дүн, тайланг жил

бүрийн 12 дугаар сард багтаан хэлэлцэж, ажлын хэсгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх эсэх, эсхүл дуусгавар болгох шийдвэрийг гаргана гэж заасныг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдсан ажлын хэсгийн явц, үр дүнгийн талаарх танилцуулгыг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд 2025 оны 7 дугаар сарын 9-нд орсон нэмэлт, өөрчлөлтөөр Аж үйлдвэржилтийн байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороод татан буугдаж, эрхлэх асуудлуудыг Эдийн засгийн байнгын хорооны харьяалалд шилжүүлсэн. Тухайн үед эдгээр Байнгын хороодын тогтоолоор байгуулагдаж байсан ажлын хэсгүүд үйл ажиллагаагаа дуусгавар болгож байгаа тухай албан бичгээ ирүүлсэн. Мөн Эдийн засгийн байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 2 ажлын хэсэг Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд санал, дүгнэлтээ танилцуулахаар удирдамжид тусгагдсан. Иймээс эдгээр ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг дуусгавар болгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулсан. Тогтоолын төсөл болон холбогдох мэдээллүүдийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Байнгын хорооны тогтоолын төсөл. Ажлын хэсгийн үйл ажиллагааг дуусгавар болгох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1. Аж үйлдвэржилтийн байнгын хорооны 2024 оны 01 04 11, 2025 оны 06 07 11 дүгээр тогтоол, Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 5 дугаар тогтоол, Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 06, 07 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болгосугай гэсэн ийм Байнгын хорооны тогтоол байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье. Нэрсээ өгье. Мөнхбаясгалан гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан.

Л.Мөнхбаясгалан: Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо татан буугдсантай холбогдуулаад олон ажлын хэсэг татан буугдаж, энд шууд хаагдаж болохоор байна. Гэхдээ бидний ажилласан ажлын хэсэг бол Монголын газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл. Энэ бол Монгол Улсын үе үеийн Засгийн газрын түүхэнд 6,2 их наяд төгрөг буюу 1,7 сая доллар авсан маш өндөр өртөг бүхий зээл юм, хөнгөлөлттэй зээл.

Гэтэл одоогийн байдлаар 6,2 их наядаасаа ерөөсөө 268,7 тэрбум төгрөгийг нь л ашиглачихсан байгаа, 4 их наяд төгрөг ашиглагдаагүй байгаа. Төслийн хугацаа дуусахад 28 онд бид хэрвээ 4 их наядыг ашиглаж дуусаагүй байвал манайд хөнгөлөлттэй зээл үзүүлсэн Энэтхэгийн Эксим банк мөнгөө татан аваад, бүх хохирлыг Монголын тал хариуцах ёстой ийм хүнд зээл. Тийм учраас энэ тухай би энэ протоколд заавал тэмдэглүүлж, ажлын хэсгийн гаргасан дүгнэлт, санал, дүгнэлтийг уншаад өгчихье гэж бодож байна. Яагаад гэхээр 2028 он болоход бид түүхэндээ байгаагүй 6,2 их наядын зээлтэй, ашиглаж амжаагүй мөнгөө буцаагаад татуулчихсан, дээрээс нь газрын тос боловсруулах үйлдвэрт ашиглагдах түүхий эдийн нөөцгүй ийм л нэг улс орон болж үлдэх вий гэдэг айдас гэх үү, болгоомжлолоос үүдэж ажлын хэсэг ажлаа хийсэн. Тийм учраас энийгээ уншиж өгөөд, гишүүд хэрвээ асуулт асуувал хариулаад протоколд үлдээе.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалангаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан Монголын газрын тос боловсруулах үйлдвэр барих талаар тавьсан асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.1 дэх хэсэгт заасны дагуу Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан тухайн асуудлаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Батбаяр, Ганзориг, Жангабыл, Золжаргал, Лувсанжамц, Мөнхтулга, Очирбат, Үүрийнтуяа, Энхтуяа, Энхтүвшин, Лүндэг нарын бүрэлдэхүүнтэйгээр ажилласан.

Биднийг энэ ажлын хэсэг ажиллаж байх хугацаанд 2025 оны 01 дүгээр сард Монгол Улсын Засгийн газар БНЭУ-ын Эксим банкнаас дахин 700 сая долларын нэмэлт зээлийн хэлэлцээрийг батлуулж, Улсын Их Хурлаар соёрхон батлуулсан. Энд ажлын хэсэг ажиллаж байсан. Тийм учраас 25 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр 05 тоот.../минут дуусав/

Р.Сэддорж: Санал, дүгнэлтийг танилцуулж дуустал хугацааг сунгая.

Л.Мөнхбаясгалан: Дугаартай тогтоолыг баталж, Монгол Улсын Засгийн газарт 7 чиглэлээр ажиллах чиглэл өгсөн байгаа. Энийг гишүүдэд бүгдэд нь тараасан учраас би энийг алгасаад, ажлын хэсэг энэ хугацаанд нийтдээ 8 удаа хуралдсан. Мөн Алтанширээгийн газрын тосны үйлдвэр дээр очиж ажилласан. ЕРС 2, 3, 4-ийг гардан гүйцэтгэж байгаа Мега Инженеринг компанитай уулзаж санал солилцсон. Тэдэнд үүрэг даалгавар өгсөн. Ингээд бид дараах чиглэлүүдээр санал, дүгнэлт гаргасан. Төслийн хэрэгжилтийн чиглэлээр, газрын тос боловсруулах үйлдвэрт түүхий эдийг нийлүүлэх чиглэлээр, дэд бүтэц, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр, орон нутгийн хамтын ажиллагааны чиглэлээр, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр, олборлолтын үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтрүүлэх чиглэлээр, төслийн хүрээнд хийгдсэн гэрээ хэлэлцээр, үнийн өсөлт чиглэлээр ингэж санал, дүгнэлт үйлдсэн.

Ажлын хэсгийн гишүүд хуралдахдаа нэгэнт 2025 оны 01 дүгээр сард Монгол Улсын Засгийн газарт 7 чиглэлээр чиглэл өгсөн учраас энэ удаа ажлын хэсгийн ажлыг дуусгавар болгож, чиглэл, тогтоолын төсөл үйлдэхгүйгээр зүгээр санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж сонсохоор шийдвэрлэсэн юм. Тэгээд энэ Энэтхэг улсаас авч байгаа 1 тэрбум 700 сая долларын зээлийн энэ төсөл бол маш их сайн анхаарч судлах ёстой. Ялангуяа сүүлд 25 оны 01 сард Улсын Их Хурлаар соёрхон батлуулсан энэ зээлийн хамгийн хэцүү заалт нь, харин энэхүү хэлэлцээрийн төслөөр 700 сая долларыг 36 сарын дотор хэрэглэж дуусгахгүй бол энэ мөнгөний зарцуулалт гарахгүй бол эх үүсвэрийг байршуулсан дундын данснаас Эксим банк үлдсэн мөнгөө бүгдийг нь шууд буцаан татах эрхтэй байхаар заасан байгаа. Гэтэл бид 8 жилийн хугацаанд үйлдвэрийг ашиглалтад оруулж чадалгүй, ашиглалтад оруулах хугацааг 3 удаа хойш нь сунгасан байхгүй юу. Тэгэхээр 36 сарын хугацаанд бид 4 их наяд төгрөгийг гаргаж, 28 онд энэ үйлдвэрийг ашиглалтад оруулна гэхчхэн байгаа.

Бас нэг эрсдэл байгаа. Энд зөвлөн, зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа, нарийвчилсан ТЭЗҮ хийж байгаа Энэтхэгийн компани энэ төслийг 2 удаа, 3 удаа бараг үнийг нь нэмэгдүүлсэн байгаа. Энийгээ их олон янзаар тайлбарладаг.

Тэгэхээр бид Монгол Улсын Их Хурал, Байнгын хороо, Засгийн газар хамтарч ажиллаж, энэ Монголын газрын тос боловсруулах үйлдвэрийн энэ төсөл дээр анхаарал тавьж, цаашид нэлээн сайн шалгаж, алдаа дутагдлыг нь залруулахгүй бол Монгол Улс 6,2 их наяд төгрөгийн өрөнд ороод, үйлдвэрээ барьсны дараа түүхий эдгүй болоод, Дорнодын Матадаас Дорноговийн Алтанширээ сум руу татсан 500 гаруй километр үргэлжилсэн шугам дамжуулах хоолой чинь хэрэгцээгүй болох вий дээ гэсэн болгоомжлолыг протоколд заавал тэмдэглүүлж үлдээе.

Тэгээд манай ажлын хэсгийн гишүүдээс бас энд байна. Тэгээд асуулт асууж, хариулбал манай гишүүд ярилцах байх. Тэгээд өнөөдрөөр ингээд ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болж байгаа юм.

Р.Сэддорж: Ажлын хэсгийнхэнд баярлалаа, Мөнхбаясгалан гишүүнд баярлалаа. Энэ дуусгавар болгож байгаа энэ ажлын хэсэгтэй холбогдуулан санал асуулт, саналтай гишүүд байна уу? Болно, Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Эрхэм гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Миний хувьд Мөнхбаясгалан гишүүний ахалсан энэ ажлын хэсэгт гишүүнээр орж ажилласан. Багагүй хугацаанд нэлээдгүй материалтай, хийсэн ажлын гүйцэтгэлийг ажлын хэсгийн гишүүд газар дээр нь үзэж танилцаж, мэдээллүүдийг нэгтгэж, дүн шинжилгээ хийж, дэд ажлын хэсгүүдэд хуваарилагдаж ажилласан байгаа. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо ажиллаж байх цаг хугацаанд эхэлсэн энэ ажлыг өнөөдөр эцэслэн дуусгаж, нэгтгэж санал, дүгнэлтээ Байнгын хороондоо танилцуулж байгаа.

Тэгээд ер нь энэ ажлын эрчимжүүлэх зайлшгүй шаардлага, ялангуяа тулгамдсан гол асуудал болох энэ санхүүжилтийн асуудлыг нэгэнт хөрөнгө нь шийдэгдсэн мөнгөө гаргаж чадахгүй байгааг бол манай юу гэдэг юм зээлдүүлэгч тал Олон улсын байгууллага нөгөө тал бол огт ойлгохгүй байгаад байгаа юм. Энэ нь манай төсвийн шаардлагад тавигддаг тусгай шаардлагуудтай холбоотой ийм асуудал. Тэгэхээр энэ бол тулгамдсан асуудал болж байна шүү гэдгийг ажлын хэсэг нэлээн бодитой дүгнэлттэй, тооцоо судалгаатай гаргаж тавьсан. Өнөөдөр энэ ажлын хэсгийн үр дүн ч тэр, Засгийн газраас барьж байгаа бодлого чиглэл ч тэр, Улсын Их Хурлын гишүүд энэ талаар ойлголт, тодорхой түвшинд хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг ойлгож, энэ гадаадын зээллэг, зээллэгийн талаарх тодорхой хууль тогтоомжийн төсөл хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явж байна гэж ойлгож байгаа.

Өөрөөр хэлбэл бид энэ нэгэнт зээлжих эрхээ авчихсан, тодорхой хугацаанд энэ зээлийнхээ дүнг гаргаж чадахгүй бол ашиглаагүй зээлийн үлдэгдэлд өдөр тутам, хоног тутам хүүгийн зардал нэмж төлөөд явж байгаа энэ нөхцөл байдалдаа маш яаралтай дүн шинжилгээ хийх ёстой юм байна лээ. Энэ ажлын хэсгийн дүн бол зөвхөн энэ төслөөр биш, цаашдаа бид зээл, тусламжаар хийж байгаа энэ хөрөнгө оруулалтын ажлуудад хийх хугацаагаа, зээлийн хүүгийн эрсдэлээ, зээлийн хүүгийн ашиглалтын хугацаагаа маш бодитой, оновчтой төлөвлөхгүй бол ийм хэмжээний санхүүгийн эрсдэлүүд үүсэж байна шүү гэдгийг гаргаж харуулсан нэг жишиг гэж үзэж байгаа юм.

Тийм болохоор ажлын хэсгийн энэ санал, дүгнэлтийг Байнгын хороонд хэлэлцүүлээд, тогтоолыг гишүүд дэмжиж өгөөд, ажлын хэсгийн үйл ажиллагааг татан буулгахыг дэмжиж өгөхийг хүсэж байгаа. Баярлалаа та бүхэнд.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн хяналт шалгалтын үйл явц, үр дүн, тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хэлэлцэж, Ажлын хэсгийн үйл ажиллагааг дуусгавар болгосон тогтоол гаргана гэж хуульд заасан байгаа. Гишүүд санал хураалтад бэлдье. Эдийн засгийн байнгын хорооны гишүүд танхимдаа яаралтай хүрэлцэн ирье.

Гишүүд санал хураалтад бэлдсэн байна. Саналын томьёолол Ажлын хэсгийн үйл ажиллагааг дуусгавар болгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдсан ажлын хэсгийн явц, үр дүн, санал, дүгнэлттэй танилцаж дууслаа.

Гурав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалдаа оръё. Чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулъя. Ажлын хэсгийн зүгээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг баримтлан боловсруулсан тогтоолын төслийн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны дарга, гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолоор Монгол Улсыг 2026-аас 30 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, мөн Монгол Улсын 2026-аас 30 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг баталж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалах, үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх тодорхой зорилт арга хэмжээнүүдийг тусгасан байгаа. Энэ бодлогын баримт бичгийг бодит үр дүнд хүргэх, болзошгүй тодорхой эдийн засгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлд заасны дагуу макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжсэн, үүнтэй уялдаа холбоотой бодлогыг Монголбанк, Засгийн газар хамтран хэрэгжүүлэх ийм зайлшгүй шаардлагууд тулгараад байгаа.

Нөхцөл байдлын хувьд харьцангуй өнөөгийн энэ геополитикийн нөхцөл байдал нэг тодорхой бус байдлын түвшин бол магадгүй 2008 оноос хойших хамгийн өндөр ийм түвшинд хүрсэн. Экспортод түшиглэсэн, уул уурхайн өндөр хамааралтай улс орнуудад томоохон бодитой ийм эрсдэлүүдийг дагуулж байна. Манай улсын хувьд энэ уул уурхайн салбарын өсөлт саарч байгаа, бүтээмж өндөртэй салбарууддаа хөдөлмөр эрхлэлт буурч байгаа, өрхийн бодит орлого, хэрэглээ суларч байгаа ийм хандлага ажиглагдаж байна. Тэгээд эдийн засгийн бодит өсөлт бол зорилтот түвшиндээ хүрэхгүй байгаа ийм нөхцөл байдал үүсэж байна. Тэгээд инфляцын бүтцийг бид судалж үзээд харахад нийт инфляцын $\frac{3}{4}$ -ыг дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт өөрөө бүрдүүлж байна.

Сүүлийн саруудад энэ нийлүүлэлтийн гаралтай инфляц өөрөө эрчимжсэн нь энэ мах, гурил, хүнсний ногоо зэрэг өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнийн өсөлттэй шууд холбоотой байгаа. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2025 оны 11 дүгээр сарын сүүлийн байдлаар инфляц 8,2 хувьтай гарсан. Энэ маань өөрөө Монголбанкны зорилтот түвшнээс нэг 4-өөс 8 хувийн интервалаар давсан

хэвээр байгаа жил бүтэн жилийн хугацаанд. Инфляцад хүнсний үнийн гол өсөлт голлож нөлөөлж байгаа. 2024 онд нийтдээ 318 барааны үнэ өсөж байсан бол 2025 онд жилийн эцсийн байдлаар аваад үзэхээр 406 барааны үнэ өсөлт бол үнийн өсөлт гарч ирээд байгаа. Тэгэхээр энэ нь өөрөө юуг харуулж байна вэ гэхээр инфляцын дарамт маань илүү өнгөрсөн онтой харьцуулахад өргөн цар хүрээг хамаарч байна.

Мөн мөнгөний салбар дээр 25 оны 11 дүгээр сарын байдлаар нэг мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 10,5 хувь болж саарсан ч, зээлийн өсөлт 21 хувьтай харьцангуй өндөр хэвээр байгаа. Бизнесийн зээлийн өсөлт давамгайлж байгаа. Ирэх онд эргээд энэ цалин, тэтгэврийн бодлогын нөлөөтэй авцалдаад энэ эрэлтийн гаралтай инфляц нэмэгдэх эрсдэл байна гэсэн ийм дүгнэлтийг хийж болохоор байгаа. Гадаад секторын хувьд голлох түүхий эдийн үнийн өсөлт төсөөллийн орчимд хадгалагдаж байгаа. Импорт өмнөх оны үеэс буурсан, ачааны болон суудлын авто машин, нефть импортын, нефтийн бүтээгдэхүүний импорт бууралт голлож байгаа.

Нөгөө талаас эдийн засгийн өсөлт 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 5,9 хувьтай, энэ өсөлтөд голлож хөдөө аж ахуйн салбар, уул уурхайн салбар голлож байгаа бол худалдаа, тээврийн салбар ахисан байдалтай байгаад байна. Өрхийн бодит орлогын өсөлт саарч байна, улсын хэмжээнд 4 хувьтай, Улаанбаатар хотод 2,9 хувь болж буурсан. Тэтгэвэр, тэтгэмж бодит дүнгээр 3,4 хувиар буурсан. Цалингийн орлогын өсөлт удааширсан. Энэ маань яг үнийн өсөлттэй хавсраад иргэдийн амьжиргаанд бодит дарамт учруулж байна. Мөн энгийн чигээр аваад үзвэл ерөөсөө өрхийн хэрэглээнд нэг эмийн импорт 2020 онтой харьцуулахад 243,3 тэрбум төгрөг байсан бол энэ нь 66,5 хувиар өссөн байгаад байгаа. Шатахууны хомсдол хийгээд, үнийн өсөлт иргэдэд нэг учирч байгаа бодит дарамтыг улам нэмэгдүүлж байгаа ийм төлөв байдал ажиглагдаж байна.

Тэгэхээр бид энэ үнийн өсөлтөөс иргэдийн бодит орлогыг хамгаалах, инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшинд хүргэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд Засгийн газраас илүү тодорхой зорилтот уялдаа холбоотой бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Улсын Их Хурал болон Засгийн газрын зүгээс үүсээд байгаа нөхцөл байдал дээр макро эдийн засаг дээр бодит дүн шинжилгээг хийх зайлшгүй шаардлагатай байна, ажлын хэсгүүдийг гаргах шаардлагатай байна. Үүн дотроо бид энэ хүнсний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, экспортын зохион байгуулалтыг сайжруулах, валютын нөөцийг тогтвортой өсгөх, өрхийн өр, орлогын харьцаа оновчтой зохицуулах, төсвийн сахилга батыг чанд хадгалах энэ бодлогын арга хэмжээнүүдэд онцгой ач холбогдолтой байхаар байна.

Тэгээд иймээс энэ иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах, төсвийн сахилга батаа нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд бодлогын тодорхой үүрэг чиглэл өгөх энэ тогтоолын төслийг боловсруулсан. Энэ тогтоолын төслийг боловсруулахад өнгөрсөн энэ долоо хоногийн хугацаанд бид холбогдох Байнгын хороодын дарга болоод Байнгын хороодын зөвлөхүүд, Их Хурлын даргаас чиглэл өгсний дагуу ажиллаад энэ тогтоолыг боловсруулсан байгааг та бүхэнд танилцуулж байна. Хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Улсын Их Хурлын Л.Соронзонболд 14 цаг 41 минутаас хуралдааныг даргалав.

Л.Соронзонболд: Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү? Жаргалан гишүүнээр тасаллаа.

Би асуулт асуух юм. Энэ ер тогтоолын төсөлтэй ерөнхийд нь танилцаад, хэд хэдэн санал өгсөн. Яах вэ зүгээр энэ дээр нэг ийм асуудал байгаад байгаа юм. Жишээлбэл Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд өгч байгаа хэсгийн эхний өгүүлбэр гэхэд яг өөрийнх нь үндсэн үүрэгтэй холбоотой өөрт нь байдаг ажлууд байхгүй юу. Тэгэхээр тиймэрхүү зүйлсийг бид заавал тэгж бичиж, тогтоолын төсөл дээр оруулах шаардлага байна уу, үгүй юү гээд нэг асуулт байгаад байна. Тэртээ тэргүй инфляцыг барих ёстой холбоотой, дээрээс нь тэр макро зохистой бодлого хэрэгжүүлэх нь Монголбанкны өөрийнх нь л үүрэгт байгаа шүү дээ. Тиймэрхүү ганц, хоёр өгүүлбэрүүд дээр нэг тийм юм харагдаад байгаа юм. Тэрэн дээр хэдүүлээ зүгээр яг тэгж орох шаардлага байсан уу, үгүй юү гэдэг нэг тийм асуулт байна. Тэмүүлэн гишүүн хариулна.

Г.Тэмүүлэн: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Яах вэ бид үндсэндээ энэ тогтоолын төсөл маань нэг бүтцийн хувьд аваад үзвэл Засгийн газарт чиглэл өгөх тухай үндсэндээ яг энэ эдийн засгийн тогтвортой байдалтай холбоотой, мөн үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхтэй холбоотой хэд хэдэн гол асуудлуудыг оруулсан. Энэ дотроосоо бид төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд 6, 7 заалтууд, мөн хувийн хэвшлийг дэмжих тогтолцооны шинэчлэлийг хийх, системийн дүн шинжилгээ хийхтэй холбоотой 6, 7 заалтууд орсон.

Энэний 2 дугаар бүлэг дээр үндсэндээ энэ Монголбанк болоод Санхүүгийн зохицуулах хороонд чиглэл өгөх 11 зүйл, заалт бүхий заалтууд орсон. Би таны эхний санал дээр бид гол үндсэндээ бид энэ өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг тогтворжуулах асуудал маань инфляцыг тогтвортой байлгах, мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх бол үндсэндээ Монголбанкны үндсэн чиг үүргийн ажил. Энийг яах вэ нэг талдаа бид энэ өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг тогтворжуулах гэдэг чиглэлээр тодотгож яах вэ энэ эхний заалт дээр оруулж өгсөн. Мэдээж Байнгын хорооны бүрэн эрх, тэгэхээр 1 дүгээр заалтыг мэдээж хасаж болно. Энэ дээр бид гол банкны салбарын реформуудтай холбоотой, тодорхой энэ санхүүгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой, валютын урсгалыг тогтворжуулж, нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой гээд зарим тодотгох асуудлуудаа 2-оос 10 дугаар зохицуулалтуудаар оруулж өгсөн гэдгийг хэлэх байна. 1 дүгээр заалт дээр таны шүүмжлэлийг хүлээж авч байна. Хэрэв шаардлагатай бол зарчмын зөрүүтэй санал гаргаад, 1 дүгээр заалтыг хасаж болно гэдгийг хэлэх байна.

Үндсэндээ бидний хувьд энэ банк давамгайлсан энэ санхүүгийн системтэй асуудал дээр л жоохон манай Монголбанк болоод Санхүүгийн зохицуулах хорооноос тодорхой дүн шинжилгээ хийж, энийг нэг өөрчлөх талаас нь ажиллахгүй бол энэ санхүүгийн зах зээлийг үндсэндээ 90 хувийг нь манай банкны салбар эзлээд байдаг. Санхүүгийн систем харьцангуй хаалттай байдаг, банк давамгайлсан бүтэцтэй байгаад байдаг. Тэгээд бид энэ асуудал дээрээ өөрчлөлтийг хийхгүй бол нөгөө талдаа санхүүгийн салбар энэ хямралд өртөх эмзэг байдал их өндөр байгаад байна. Тэгээд бид энэ ч байдлаасаа болоод түүхэн хугацаандаа энэ банк санхүүгийн салбарынхаа энэ доголдсон энэ системээс болж үндсэндээ түүхэн хугацаандаа нэг ийм өндөр инфляцтай явж ирсэн байгаад байгаа.

Цаашид зөвхөн санхүүгийн салбараас гадна, инфляцыгаа онилох энэ мөнгөний бодлого макро зохистой бодлогоо илүү оновчтой болгох ийм зайлшгүй

шаардлагууд байна. Инфляцад нөлөөлж байгаа хүчин зүйл факторуудаа дотоод болоод гадаад нөхцөл байдлаас нь үнэлж харах зайлшгүй шаардлагууд байна гэдгийг тодорхой мэдээлэл болгож хэлэх гэсэн юм.

Л.Соронзонболд: Бас нэг тодруулаад асуулт асуучихъя. Энэ юун дээр 1 дүгээр хэсгийн 2 дахь дээр энэ уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай ингээд нөгөө сөрөг нөлөө үзүүлэхүйц тээвэртэй холбоотой аливаа нэмэлт зохицуулалт шийдвэр гаргахгүй байх гээд. 2-т нь болохоор нөгөө Засгийн газарт өгч байгаа төсвийн зарлагыг нэмэгдүүлэхгүй хэсэг дээр болохоор энэ Хөрөнгийн биржийн төрийн өмчийн хувьцааны эзлэх хувийг бууруулж, нээлттэй хувьчлах гээд. Энэ маань нөгөө бид чинь төрийн өмчит ААН-ийн нөгөө нээлттэй, ил тод биржээр арилжаалах гээд нөгөө хуулийн төсөл үндсэн чиглэл дээр яваад байгаа шүү дээ. 2, 3-йг нэг холбогдох нэг төрийн өмчийн компаниудтай холбоотой заалтууд орсон байгаа юм. Энэ дээр нэг жоохон тайлбар өгөөч. Яагаад бүүр ингээд зориуд цохон тэмдэглэж оруулж байгаа вэ гээд. Тэмүүлэн гишүүн хариулъя.

Г.Тэмүүлэн: 2 дахь хэсэгтэй холбоотойгоор саяын таны онцолж хэлээд байгаа энэ хөрөнгийн биржийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг сайжруулах энэ асуудлыг онцолж тусгаж өгсөн байгаад байгаа. Энэ дотроо бид үндсэндээ яг эдийн засгийг аваад үзвэл манай эдийн засагт болоод дотоодын нийт бүтээгдэхүүнд өсөлтөд нөлөөлж байгаа гол үндсэн зүйл маань энэ гадаадын шууд хөрөнгө оруулалтын асуудлууд байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүн нөлөөллийн хувьд нь зүгээр бид аваад үзэхээр хамгийн том хүчин зүйл байдаг энэ өөрөө. Тэгэхээр нэг ойролцоогоор 20 орчим хувьтай байдаг. Бидэнд үндсэндээ сүүлийн 10 жилийн хугацаанд бодит үнэн нөхцөл байдал гээд аваад үзвэл хөрөнгө оруулалт гэдэг зүйл орж ирсэнгүй. Хөрөнгө оруулалт гэдэг зүйл байхгүй болчихоод байна. Тэгэхээр бид нэг талдаа энэ өөрсдөөс хамаарах энэ зүйл дээрээ нэг бодитоор нь дүн шинжилгээ хийж харахгүй бол болохоо больчихоод байна гэж хараад байгаа. Өнөөдөр Монголын хөрөнгийн бирж маань төрийн.../минут дуусав/

Л.Соронзонболд: Тэмүүлэн гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Г.Тэмүүлэн: Яг үндсэндээ 66 хувь нь төрд байгаад байдаг, 34 хувь нь олон нийтийн байдлаар хувьцаа нь тархсан байгаад байгаа. Тэгэхээр үндсэндээ дэлхий дээр аваад үзвэл төрийн өмчийн бирж гэдэг хувилбар бараг миний мэдэхээр л лав байхгүй байгаад байгаа. Тэгэхээр бид энийг илүү нэг хувьчилж, илүү хөрөнгө оруулалт татах, илүү энэ хөрөнгийн зах зээлийг энэ салбар дахь үйл ажиллагааг нь сайжруулах үүднээс төрийн өмчийн энэ хувьцааны эзлэх хувийг зайлшгүйгээр бууруулаад, уг нь болж өгдөг бол нээлттэйгээр энэ хувьчлах энэ асуудлыг Засгийн газар судлаад нэг оруулж ирэх зайлшгүй шаардлагатай байна гэж хараад байгаа. Бүр болж өгвөл юу гэдэг юм Солонгосынх байна уу, Сингапурынх байна уу, хаанахын байна энэ хөрөнгийн биржүүдтэй хамтарч ажиллах, мэргэжлийн байгууллагууд болоод энэ хөрөнгө оруулагч нартай урт хугацааны гэрээ байгуулж ажиллуулах энэ системийн өөрчлөлтийг хийх зайлшгүй шаардлага байна гэж үзээд байгаа юм. Тэгээд энэ үүднээс энийг оруулж ирсэн. Хөрөнгийн зах зээл өөрөө шинэчлэгдэхгүйгээр цаашид бид хөрөнгө оруулалт татна гэсэн зүйл байхгүй болчихоод байгаа юм.

Л.Соронзонболд: Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Өнгөрсөн 11 сарын Улсын Их Хурлын асуулгын цаг дээр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Ерөнхий сайдаас бас яг энэ үнийн өсөлт

гэдэг сэдвийн дагуу асуулга хийсэн. Энэ хүрээнд маш олон салбарт үнийн өсөлт хэрээс хэтэрсэн. Зарим зүйл нь болохлоор энэ зохицуулалтын алдаанаас болсон. Ер нь Монголын эдийн засагт амьжиргааны өртгийн хямрал буюу энэ cost of living crisis гэдэг ийм зүйл тулгамдаад байгаа талаар л бид ярьсан байгаа. Тэр утгаараа энэ амьжиргааны өртгийн хямралтай хэрхэн, яаж тэмцэх юм, макро эдийн засгийн бодлогын хүрээнд, төсвийн бодлогын хүрээ, мөнгөний бодлогын хүрээнд ер нь яаж энэ асуудалтай тэмцэх гэдэг дээр ач холбогдол өгч байгаа нэг. Тэр утгаараа энэ тогтоолын төсөлд дурдагдсан зарим нэгэн асуудлуудыг дэмжиж байна.

Нөгөө талаас сая Соронзонболд гишүүний хэлдгээр хэтэрхий ерөнхий, угаасаа тухайн байгууллагуудын ажлын чиг үүрэгт багтсан, гүйцэтгэх засаглалын хариуцах шинж чанартай ийм агуулгууд багтсан нь Улсын Их Хурлаас ийм тогтоолууд бид батлаад байхлаар юу гэдэг юм дараа нь энэ тогтоолынхоо хэрэгжилтэд хяналт тавих боломжгүй, хэт ерөнхий, гүйцэтгэлийг нь хянах, тогтоолынхоо хэрэгжилтийг дүгнэх тийм KPI байхгүй ийм нөхцөл байдал руу оруулж байна гэсэн нэг зовнил байна. Түүнээс гадна илүү том асуудал нь юу байна вэ гэхлээр энэ тогтоолын төслийг ер нь хэн санаачлаад, яагаад өнөөдөр Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн гар дээр ирж байна вэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Яагаад вэ гэхлээр уул нь парламент дээр ингээд маш олон удаагийн хэлэлцүүлэг яваад, аливаа асуудлыг чанаад, тэгээд энэ Улсын Их Хурлын гишүүдийн нөгөө мэдэх эрхийг хангаад гэдэг шиг ингэж байж энэ парламентын мэтгэлцээний явцад аливаа асуудал дээр нийгэмд ч тодорхой ойлголт өгөөд, тэгээд ингээд юу гэдэг юм асуудлыг илүү боловсруулаад, тэгээд дараа нь бид тогтоолоо ч гэдэг юм уу, хууль тогтоомжоо батлах ёстой.

Гэтэл энэ тогтоол бол сая яг дөнгөж энэ Байнгын хорооны хурал зарлагдаад, хурал эхлэхэд л ирлээ. Тэгээд Эдийн засгийн байнгын хорооноос санаачилж байгаа тогтоол юм бол яагаад Эдийн засгийн байнгын хорооны гишүүд нь энэ талаар мэдэхгүй, хаагуур өнгөрчхөв гэдэг асуудал байна. Тэгэхээр эндээс би энэ Улсын Их Хурлын Тамгын газрынхнаас бөгөөд энэ тогтоол яг ямар горимоор, яаж санаачлагдаад, яагаад өнөөдөр энэ Байнгын хороогоор орж ирээд, тэгээд үдээс хойш шууд нөгөө чуулганы хуралдаанаар орохоор тавьчихсан байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ нөгөө нэг бид парламентын юу гэдэг юм хяналт шалгалтын эрх, юу гэдэг юм парламент дээр байгаа энэ нээлттэй, ил тод байдлыг хамгаалахыг хүсэж байгаа бол тэр нөгөө агуулга нь зөв, буруу байснаас үл хамаараад энэ нөгөө дэг чинь, процесс нь нээлттэй, ил тод явах ёстой. Тэгэхээр 30-нд орж ирээд, 30-ныхаа орой баталдаг баймааргүй байна. Тэгэхээр энэ дээр надад нэг тодорхой хариулт өгөөч, хаанаас орж ирээд, яагаад.../минут дуусав/

Байнгын хорооны дарга Р.Сэддорж 14 цаг 51 минутаас хуралдааныг даргалав.

Р.Сэддорж: Тэмүүлэн дарга.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурал хуульд заасан хугацааныхаа дагуу 2026-аас 2030 оны Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг баталсан. Тэгээд үндсэндээ үндсэн чиглэлийг бид батлах үед Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсгийн хувьд гол энэ макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахтай холбоотой асуудлуудыг голлож үзсэн. Энэ дотроо ирэх 5 жилийн хугацаанд энэ эдийн засгийн өсөлтийг 6 хувиас багагүй түвшинд хадгалах, инфляцыг 5 хувь хүргэх, ядуурлыг 15 хүртэл бууруулах ч гэдэг юм уу энэ гол, гол эдийн засгийн, макро эдийн засгийн параметрууд голлож энд орсон, ажилласан.

Тэгэхээр үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурал нэн яаралтайгаар ажиллах зайлшгүй шаардлагатай байна. Монголбанк болоод Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн мэдээллүүдийн хүрээнд ирэх саруудад энэ бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт нэлээн чангарах, ингээд эдийн засгийн өсөлт ч гэсэн тодорхой хувиар нөлөөлөх ийм зүйлүүд голлож харагдаад байгаа. Тэгэхээр бид учирч болзошгүй эрсдэлийг илүү харж, одоогийн макро эдийн засгийн нөхцөл байдал дээр нэг бодит дүн шинжилгээ хийж, Улсын Их Хурал илүү санаачилгатай ажиллах шаардлагатай байна гэсэн чиглэлийг ингээд Улсын Их Хурлын даргаас өгсөн. Энэ хүрээнд үндсэн чиглэлийг баталсан ажлын хэсгийн зүгээс тодорхой яг үндсэн чиглэлтэйгээ холбогдуулаад эргээд бид бүхний хувьд энэ ирэх 3 сар хүртэлх энэ хаврын чуулган хүртэлх 3 сарын хугацаанд ерөнхийдөө энэ Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газартай хамтарч ажиллах энэ ажлын хэсгийг Их Хурлаас байгуулах шаардлагатай байна гэж хараад байгаа Их Хурлын даргын захирамжаар.

Энэ хүрээнд эрчимжүүлэх хүрээнд саяын энэ чиглэл болгож байгаа энэ 20 орчим заалт бүхий энэ тогтоолын төслийг ингээд боловсруулж орж ирсэн. Тэгэхээр энэ тогтоолын төсөл маань үндсэн гол агуулга, уялдаа холбоо маань үндсэн чиглэлтэйгээ шууд уялдаж холбогдож байгаа. Энэ дотроо бид аль болох л энэ бодлогын тогтолцооны өөрчлөлтүүдийг хийх тал дээр анхаарахгүй бол үндсэндээ манай энэ ядуурлын түвшин болоод бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийн асуудлууд маань цэвэр эдийн засгийн өрөөсгөл бүтэцтэй холбоотой асуудлууд байгаа. Тэгэхээр бид энэ хүрээнд яах вэ Улсын Их Хурал яг энэ эдийн засаг дахь энэ бүтцийн алдаа оноонуудыг илүү залруулах талаас нь бодлогын чиглэлээр нь ажиллаж, тодорхой 3 сар гэхэд шаардлагатай бол тогтолцооны болоод бодлогын өөрчлөлтүүдийг өөрсдөө санаачилж оруулж ирье гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа гэдгийг хэлэх байна.

Мэдээж цаг хугацаа нэлээн жоохон шахуу хүрээнд холбогдох манай Эдийн засаг, Төсвийн байнгын хороо болоод Аюулгүй байдлын байнгын хорооны референт болоод Байнгын хорооны дарга нарын түвшинд бид ингээд ажиллаад ерөнхий энэ саналыг та бүхэнд бодлого болгож ингээд оруулж ирж байгаа. Тэгээд энэ зөвхөн зүгээр тогтоол гараад зогсох биш, ирэх хаврын чуулган хүртэл ингээд эрчимтэйгээр ажиллах зайлшгүй шаардлага байна гэж.../минут дуусав/

Р.Сэддорж: Жаргалан гишүүн тодруулж асууна.

Б.Жаргалан: Тэгэхээр энэ Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл гэдэг бол нөгөө Засгийн газрын даалгавар байгаа. Тэгээд энэ 5 жилийн үндсэн чиглэлийг баталсан ажлын хэсэг боловсрууллаа гээд тэгээд Улсын Их Хурал руу, Байнгын хороод руу энэ янз бүрийн тогтоолын төсөл батлаад байх ийм хонгил угсарчихсан юм байна шүү дээ. Тэгээд өмнөх долоо хоногт нөгөө эрчим хүчний тархмал эх үүсвэр гэдэг тогтоол яг энэ шугамаар орж ирсэн, яг тухайн өдрөө батлагдсан. Тэгээд энэ удаад болохлоор ерөөсөө 12 сарын 30-ны өдөр Эдийн засгийн байнгын хороон дээр шууд орж ирээд, үдээс хойш нь болохлоор чуулганаар орно гэсэн байдлаар ингэж оруулж ирж байна. Би зүгээр зарчмын хувьд ийм хугацаа дээр, ямар ч гишүүдийн мэдэх эрхийг хангалгүйгээр, тэр агуулга нь зөв байна уу, буруу байна уу дараачийн асуудал. Гэхдээ энэ дээр чинь нэг нийгмийн хэлэлцүүлэг явах ёстой, гишүүд энэ дээр танилцсан хугацаа байх ёстой. Би Улсын Их Хурлын даргыг ойлгож байна. Монгол Ардын намын даргын хувьд ингээд нэг ийм тодорхой

ийм, ийм зүйл дээр би идэвх санаачилга гаргаад, ийм тогтоол батлуулсан гэдэг ийм улс төрийнхөө оноо.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Сая яг яах вэ нэг талдаа жоохон шахуу байдлаар ингээд ажлын хэсэг ажиллаад энэ тогтоолын төслийг оруулж ирж байгаа дээр хүлцэл өчиж байна. Тэгэхдээ нөхцөл байдал өөрөө бидний талд биш байгаад байгаа, олон улсын нөхцөл байдал чинь өөрөө яг магадгүй л би түрүүн хэлсэн 2008 оноос хойших хамгийн ийм эргэлзээтэй, тодорхойгүй ийм нөхцөл байдалд байгаад байна. Тэгэхээр он гараад магадгүй яг макро эдийн засаг талаасаа нэлээн асуудлууд хурцаар тавигдахаар, энэ тогтоол хурдан явахаас өөр арга байсангүй л гэж харсан. Тэгэхээр энэ тодорхой ташуур өгч Засгийн газар болоод Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтарч ажиллах зайлшгүй шаардлага бол төрийн эрх барих дээд байгууллагын хувьд байна л гэж үзсэн. Энэ хүрээндээ л одоо бид яг үндсэн чиглэл баталсан гол бодлогуудынхаа хүрээнд тэрнийхээ залгамж болгоод ирэх нэг жилийн хугацаанд, мөн бүүр ойрын хугацаандаа аваад үзвэл 3 сарын хугацаанд бид бас нэг энэ хэрэгжүүлэх шуурхай бодлогуудыг гаргаж ажиллая л гэж үндсэндээ ингээд төлөвлөөд оруулж ирсэн. Тэгээд хугацаагаар шахаж оруулж ирсэнд хүлцэл өчье.

Р.Сэддорж: Даргын дэргэдэх зөвлөл дээр энэ асуудал яригдаад, тэгээд ингээд хэлэлцэх асуудалд орсон байгаа. Мөн Улсын Их Хурлын дарга холбогдох Байнгын хорооны дарга нар болон холбогдох харьяа байгууллагын дарга нарыг дуудаж уулзаж анх энэ тогтоолын төслөө танилцуулсан. Ингээд Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэгдэж байна. Өнөөдөр ингээд дэмжигдвэл 01 сарын 01-нээс эхлээд энэ тогтоолын дагуу Засгийн газарт чиглэлд очиж, үйл ажиллагаа нь энэ тогтоолын дагуу сайжирна. Тэгээд хамгийн тулгамдсан асуудлуудыг энд оруулсан байгаа гэж ойлгож байгаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төслийг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Чиглэл өгөх тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Нэг.Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолд заасан Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалах, үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

1.Үнийн өсөлтөөс сэргийлэх, түүний эрсдэлийг бууруулах зорилгоор төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангаж төсвийг хэт тэлэх эрэлтийн гаралтай инфляц үүсэхээс сэргийлэх, дотоодын зах зээл дэх мөнгөний нийлүүлэлтийг огцом нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхгүй байх.

2.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлэхүйц тээвэртэй холбоотой аливаа нэмэлт зохицуулалт, шийдвэр гаргахгүй байх.

3.Хилийн боомт, гаалийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж төр өөрт байгаа мэдээллийг давхардуулан шаардахгүй байх, нэвтрэх хугацааг богиносгох замаар

тээврийн зардлыг бууруулах, тээвэр логистикийн саатлаас шалтгаалан импортын барааны үнэ өсөхөөс урьдчилан сэргийлэх.

4.Уул уурхайн салбарын өсөлтөөс үүдсэн төсвийн хэт тэлэлтээс хамгаалах бодлого боловсруулж хэрэгжүүлэх, төсөв, төсвийн сахилга батыг чангатгах, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс бий болсон нэмэлт орлогыг хуримтлуулах, боловсруулах, үйлдвэр, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, эрчим хүч, дэд бүтэц, боловсрол, технологи зэрэг бусад боломжит салбарт хөрөнгө оруулалт хийх замаар эдийн засгийг төрөлжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх.

5.Барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, оюуны өмчөөр хамгаалагдсан эсхүл нарийн технологи шаардсанаас бусад төрөөс хэрэгжүүлж байгаа томоохон төслүүдийн худалдан авалт, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажилд дотоодын аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг дэмжих, шаардлагатай тохиолдолд дээрх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг шинэчлэх санал боловсруулж танилцуулах.

6.Эмийн зохицуулалтын төлөвшлийн түвшин өндөртэй улсуудаас чанартай эмийг бөөнөөр худалдан авч, ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар эмийн үнийг бууруулах. Зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарласан зохицуулалтыг хялбаршуулж, үнийн өсөлтөд хяналт тавих

7.Төрөөс үнийг зохицуулж байгаа салбаруудыг инфляцад огцом нөлөө үзүүлэхгүй байхаар тооцож, үе шаттайгаар чөлөөлөх, зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарласан бүх төрлийн төрийн зохицуулалтыг хялбаршуулах.

8.Төсвийн зарлагыг нэмэгдүүлэхгүйгээр доор дурдсан арга хэмжээг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг хамгаалах:

А.Төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор төсвийн байгууллагын бүтэц, чиг үүргийг бүх шатад нягталж, давхардсан чиг үүрэг байгууллагыг нэгтгэх, татан буулгах, хувийн хэвшлийн гүйцэтгэх боломжтой төрийн ажил, үйлчилгээг хязгаарлах, нийгмийн болон дэд бүтцийн салбарын суурь үйлчилгээг гэрээний үндсэн дээр шаардлагатай нөөцийг ашиглан хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх.

Б.Бүтээмж, гүйцэтгэлд суурилсан төрийн албан хаагчийн цалин хөлс, тэтгэмж, урамшууллын тогтолцооны загварыг боловсруулж, ур чадвар, үр дүнтэй уялдуулсан цалин урамшууллын системийг нэвтрүүлэх.

В.Үр өгөөж бага олон нийтийн арга хэмжээ, сурталчилгаа, гадаад томилолт, автомашин, тавилга худалдан авах зэрэг урсгал зардлыг үе шаттайгаар бодитой бууруулах.

Г.Хөдөө аж ахуй болон бусад салбарын татаас, урамшуулал, татварын хөнгөлөлтийн үр дүнг тооцож, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлдэггүй, зорилтот бүлэгт хүрдэггүй дэмжлэгийг өөрчлөх, бүрмөсөн зогсоох.

Д.Засгийн газрын тусгай сангуудын давхардлыг арилгаж, зарим сангуудыг татан буулгах, сангуудын үйл ажиллагааг ил тод болгож, хяналтыг сайжруулах, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, танилцуулах.

Е.Төрийн хяналт шалгалтын тогтолцоог шинэчилж, эрсдэлд суурилсан давхардал, хүнд сурталгүй, цахимжсан төрийн хяналтыг бэхжүүлж, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлдэг тогтолцоог төлөвшүүлэх.

Ё.Бизнес эрхлэхэд хүндрэлтэй, чирэгдэл учруулж байгаа баримт бичгийг хүчингүй болгох, тоог цөөлөх арга хэмжээг авах.

Ж.Хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжихэд чиглэсэн бизнесийн шударга өрсөлдөөн, эрх тэгш байдлыг хангах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх арга хэмжээг авах, шаардлагатай бол холбогдох хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулах.

З.Хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох үүднээс ядуурал, ажилгүйдлийг бууруулах, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын шинэчлэлийг орлогыг дахин хуваарилалттай хамтад нь хийх асуудлыг цогцоор нь судалж, холбогдох хуульд өөрчлөлт оруулах саналыг боловсруулах.

И.Хөрөнгийн биржийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг сайжруулах үүднээс тус биржийн төрийн өмчийн хувьцааны эзлэх хувийг бууруулах, нээлттэй хэлбэрээр хувьчлах, мэргэжлийн байгууллага хөрөнгө оруулагчтай урт хугацаанд гэрээ байгуулж, хамтран ажиллах хувилбаруудыг судалж танилцуулах.

Хоёр.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанканд, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус даалгасугай:

1.Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг тогтворжуулах, иргэдийн бодит орлогыг хамгаалах чиглэлээр мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх.

2.Гадаадын банкны салбаруудыг холбогдох хуулийн дагуу дотоодын зах зээлд нэвтрүүлж, өрсөлдөөнийг дэмжих, санхүүгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээг авах.

3.Банкны салбарын реформыг эрчимжүүлж, зээлийн хүүг үе шаттайгаар бууруулах.

4.Хөнгөлөлттэй ипотекийн зээлийг агаар, орчны бохирдол, төвлөрлийг бууруулах зорилгоор зорилтот бүлэгт чиглүүлэх, эх үүсвэрийн бодит өртөг зах зээлийн зарчимд нийцүүлэн ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

5.Гадаад валютын хэрэгцээ, гадаад өр төлбөр, импортын урсгалыг харгалзан гадаад валютын нөөцийг зохистой түвшинд хүргэх. Санхүүгийн хэрэгслүүдийг оновчтой ашиглах замаар гадаад валютын урсгалыг тогтворжуулж, нөөцийг нэмэгдүүлэх.

6.Монголбанкны өнгөрсөн хугацааны алдагдлыг нэмэгдүүлсэн суурь шалтгааныг тогтоож, хуримтлагдсан алдагдлыг үе шаттай бууруулах.

7.Гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн зөрөөнөөс үүдэлтэй ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлийг бууруулах талаар Монголбанкны хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой болгох.

8.Иргэдийг хэрэглээний зээлийн хэт өсөлт, их хэмжээний өрийн дарамт, цахим зээлийн давхардлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зээлийн мэдээллийн бодит цагийн горимоор зээлийн мэдээллийн санд нийцүүлэх арга хэмжээ авах.

9.Банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуульд заагаагүй зөвшөөрөл, зөвшөөрөлтэй төстэй зохицуулалт бүхий баримт бичгийг цуцалж, хүнд суртлаас чөлөөлөх.

10.Банк, санхүүгийн байгууллагууд өөрийн харилцан хамаарал бүхий этгээдээр дамжуулан лизинг, мөнгөн зээлийн үйл ажиллагааг хууль бусаар эрхэлж байгааг таслан зогсоох, иргэд, ААН-ийн эрх ашгийг хамгаалах холбогдох хуульд зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авах.

Энэхүү тогтоолын хэрэгжилтийн явц, биелэлтийн талаар Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын чуулганд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт, Монголбанканд, Санхүүгийн зохицуулах хороонд, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд, Төсвийн байнгын хороонд тус тус даалгасугай. Тогтоолын төсөл дээр саналтай гишүүд байна уу? Тогтоолын төсөл дээр саналтай гишүүд нэрсээ өгье. Цэнгүүн гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа.

Д.Үүрийнтуяа: Тогтоолын төслийг дэмжиж байгаа. Тэгээд хэд хэдэн санал байна, найруулга редакцын гэж хэлж болно. 1 дүгээрт, энэ Монгол Улсыг 2026-аас 30 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталсан тэр 109 дүгээр тогтоолд заасан энэ арга хэмжээний хүрээнд гээд байгаа юм. Тэгээд 109 дүгээр тогтоолд заасан тэр арга хэмжээний хүрээнд гэх нь оновчгүй байгаад байгаа юм л даа. Баталсан тогтоолд заасан арга хэмжээ биш, яг тэр үндсэн чиглэлд заасан асуудлаа үндэслэж бид энэ тогтоолыг гаргах гээд байгаа юм. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд. Тэгэхээр энэ дээр редакцын засвар хийхээр саналтай байна.

3 дээр, 1.3 дээр гэсэн үг мөн ялгаагүй энэ нэг нэвтрэх хугацааг богиносгохын тулд тээврийн, богиносгосноороо тээврийн зардал бууруулах юм шиг нөгөө шалтгаан, үр дагаврынхаа байр суурийг л нэг буруу тодорхойлоод байгаа юм шиг харагдаад байх юм. Уг нь ерөөсөө л импортын барааны өсөлтөөс урьдчилан сэргийлэхийн тулд ийм, ийм арга хэмжээг авч хэрэгжүүл л гэж заамаар байгаа байхгүй юу.

5 дээр барилгын материалын импортыг, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гээд байгаа юм. Тэгэхээр зөвхөн бид барилгын материал дээр хязгаарламааргүй байна л даа. Үндсэндээ бид импорт орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг л бүтнээр нь дэмжмээр байна. Зөвхөн барилгын материал дээр биш. Импорт орлох үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих гэдгээрээ оруулж өгвөл яасан юм бэ.

8 дээр нийтдээ нэлээн хэд хэдэн ингээд заалтуудыг дотор нь оруулж өгч байгаа юм энэ нэгдсэн агуулгаар. Өөрөөр хэлбэл энэ төсвийн зарлагыг нэмэгдүүлэхгүйгээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүл гээд. Энэ дээр нэгтгэж болох хэд хэдэн заалт харагдаад байгаа юм. Жишээлбэл А, Б хоёр бол үндсэндээ төрийн бүтэц, төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэгээд хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх, энэ төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын цалин хөлс, урамшууллыг гүйцэтгэлтэй нь уялдуулж олгодог болох л гэсэн нэг агуулга яваад байгаа юм. В-д байгаа асуудал бол ерөөсөө Төрийн

хэмнэлтийн хуульд заачихсан арга хэмжээ. Тэгэхээр Төрийн хэмнэлтийн хуульд заачихсан арга хэмжээг давхардуулан оруулж ирэх нь ер нь ямар байх юм бол.

Ард нь энэ 2 дахь хэсгээр Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороонд хэд хэдэн үүрэг өгч байгаа. Энэ үүрэг өгсөн заалтуудыг харахаар нэгд мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх гээд байгаа юм. Эдийн засгийн онолоор бол бид макро зохистой бодлого гэхээс илүү макро эдийн засгийн тогтвортой бодлого хэрэгжүүлэх тухай асуудал л яригдах байх. Мөнгөний бодлого, макро эдийн засгийн тогтвортой бодлого хэрэгжүүлэх арга хэмжээ гэдгээрээ тодотгож, нэр усыг нь янзалбал яасан юм.

2 дээр гадаадын банкны салбаруудыг гээд байгаа юм. Тэгээд энэ нь өөрөө гадаадын нэг банкны хэд хэдэн салбар орж ирэх юм шиг ойлголт төрүүлээд байхгүй юу. Тэгэхээр гадаадын банкнуудын салбарыг гэдэг энэ олон тооны хамаатуулах нөхцөлөө хаана залгах вэ гэдгээ бодож залгамаар байна. Үндсэндээ 2, 3 дахь асуудлыг нэгтгэчихмээр байгаа юм. Яг банкны салбарын реформ, банкны салбарын төгс өрсөлдөөнт зах зээл рүү шилжүүлэх тухай асуудал байгаа. Энэ.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Тэгэхээр энэ банкны салбарын зах зээлийг олигопол зах зээлээс нь илүү төгс өрсөлдөөнт шилжүүлэх асуудал одоо тусгагдаж байгаа учраас энэ 2 асуудлыг нэгтгээд оруулчихвал яасан юм бэ гэж. Ер нь энэ Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгаж байгаа энэ чиг үүргүүдийг харахаар ингээд нэг мөнгөний бодлого, нэг банкны бодлого, эргээд мөнгөний бодлого гээд ингээд л холилдож харагдаад байгаа юм. Энийгээ нэг жаахан агуулгынх нь хувьд дэс дарааллыг нь өөрчлөөд эрэмбэлэх асуудал дээр анхаармаар байгаа юм.

3 дахь асуудал, 3-д гэдэг дээр тогтоолын хэрэгжилт хамгийн сүүлд энэ тогтоолыг хэрэгжүүл, тайлагна, хяна гэдэг 3 үүргийг аль ч тогтоолын төсөл дээр хамгийн сүүлд өгөгддөг. Тэгэхээр энэ дээр үзэхээр үндсэндээ зүгээр тайлагнах, дээрээс нь хянах 2 үүрэг л орж ирээд байгаа байхгүй юу. Тэгээд хэрэгжилтийн явц, биелэлтийн талаар л Их Хуралд тайлагна гээд байгаа юм. Энийг чинь эхлээд хэрэгжүүлэхийг нь, шуурхай хэрэгжүүлэх үүргийг нь өгмөөр байна. Дараа нь энэ биелэлтийнхээ тайланг заалт бүрээр оруулж ир гэж нарийвчилж зааж өгмөөр байна. Тэгээд гүйцэтгэлийг нь хянах үүргийг нь өгмөөр байна. Тэгэхгүй энэ чинь.../минут дуусав/

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүний гаргасан саналыг бичгээр санал хураалгахад бэлдье, бичгээр. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

Л.Соронзонболд: Миний хувьд энэ 2 дугаар зүйлийн эхний хэсгийг хасах саналтай байгаа юм. Өөрөөр хэлбэл Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны өөрийнх нь үндсэн үүрэгт нь орж байгаа байна гэж үзэж байгаа учраас хасах саналтай байгаа юм. 2.1-ийг.

Р.Сэддорж: Санал хураалт, санал хураалгана. Бэлэн байгаа юу? Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн.

С.Цэнгүүн: 2.1-ийг хасах, өмнөх юутайгаа логик нь авцалдахгүй байгаад байна. Соронзонболд гишүүнтэй адилхан, хамт өгчихсөн ч болно. Тийм, хамт өгчихсөн ч болно, нэг юун дээр.

Р.Сэддорж: Төслийн 1 дүгээр заалтад надад бас санал байгаа. Доор дурдсан агуулгатай шинэ дэд заалт нэмэх. Санал хураалгах болсон үндэслэл нь Монгол Улсын тээврийн бизнес эрхэлж байгаа бүх компаниуд дампуурч байгаа. Тэгээд энэ бол нөгөө Биржийн тухай хууль бол тээврийг Биржийн хуульд оруулж, тээврийн үнийг тэр үнэд нь оруулаад, тэгээд төрийн худалдан авахаас тээврийн компанийг нь сонгож өгдөг байдлаас болж энэ тээврийн салбар бол бүгд дампуурч байна. Өөрөөр хэлбэл хамгийн бага үнэ өгөх аж ахуйн нэгжид тээврийг нь өгдөг. Тэгээд хамгийн бага үнийг хэн өгөх вэ гэхээр тухайн олон машинтай, магадгүй гадаадын компаниуд л өгдөг. Тэгэхээр Монголын 1, 2 машинтай тээврийн жолоочид, бизнес эрхэлдэг иргэд, ААН-үүд ер нь маш хүнд байдалтай байгаа. Тэгээд энэ дээр энэ саналыг оруулж байна. Тогтоолын төсөл, саналын томъёолол бол тогтоолын төсөлд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагааг биржийн арилжаанаас салгаж, бие даасан байдлаар зохицуулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах гэсэн шинэ дэд заалт нэмэх. Санал гаргасан миний бие.

Гишүүд санал хураалтад бэлдье. Тогтоолын төслөөс 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг тогтворжуулах, иргэдийн бодит орлогыг хамгаалах чиглэлээр мөнгөний бодлого, мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ гэсэн энэ заалтыг хасах саналыг гаргаж байна. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд, Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн нарын зүгээс энэ саналыг гаргаж байна. Соронзонболд, Цэнгүүн нарын гишүүдийн гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 44,4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Төслийн 1 дүгээр заалтад доор дурдсан агуулгатай шинэ дэд заалт нэмэх.

Монгол Улсад санал хураалт, үндэслэл нь болохоороо Монгол Улсын тээврийн бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэд маань маш хүнд байдалтай байгаа. Өөрөөр хэлбэл төрийн худалдан авах байгууллагаар тээвэр хийх байгууллагыг сонгодог, тэгээд хамгийн бага үнэ өгсөн компанийг шалгаруулдаг. Хамгийн бага үнийг гадаад орны компаниуд өгч байгаа учраас Монголын автомашинтай тээвэр гүйцэтгэдэг жижиг аж ахуйн нэгжүүд, хувь хүмүүс ингээд ер нь бүрэн дампуурч байгаа. Энэ тээврийг зах зээлийн зарчимд нь орхихоо, Биржийн хуулиас арай салгачих хэрэгтэй юм гэсэн. Тэгээд саналын томъёоллоо уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөлд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үйл ажиллагааг биржийн арилжаанаас нь салгаж, бие даасан байдлаар зохицуулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах гэсэн дэд шинэ дэд заалт нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сэддорж. Энэ гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Очирбат гишүүнийг дэмжсэнээр оруулъя.

Саяын санал дэмжигдсэнтэй холбогдуулан энэ 2 дугаар заалт буюу 1.2 дугаар заалт Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлэхүйц тээвэртэй холбоотой аливаа нэмэлт зохицуулалт, шийдвэр гаргахгүй байх гэдэг заалтыг хасах юм байна. Тийм. Хасахгүй бол хоорондоо зөрчилдөж байгаа юм байна. Ингээд энэ заалтыг хасахыг дэмжье гэсэн

томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үүрийнтуяа гишүүн өөрөө саналаа уншаад, тэгээд санал хураалгаад явчихъя. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: 1 дэх санал тогтоох нь гээд 1 дэх хэсгийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хүрээнд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалах, үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Занданшатар/-т даалгасугай. Үүнд гэж өөрчлөх.

Р.Сэддорж: Санал гаргасан Үүрийнтуяа гишүүн. Үүрийнтуяа гишүүний гаргасан саяын уншсан зарчмын зөрүүтэй саналаар саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Дараагийн саналын томъёоллыг Үүрийнтуяа гишүүн уншина. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: 1 дэх хэсгийн 3-д хилийн боомтууд, гаалийн үйл ажиллагаа болон тээвэр логистикийн саатлыг багасгаж, импортын барааны үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэхийн тулд боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, дэд бүтцийг шинэчлэх, гаалийн бүрдүүлэлтийг бүрэн цахимжуулах, хяналтыг нэгдмэл удирдлагын тогтолцоонд оруулах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх гэж өөрчлөх.

Р.Сэддорж: Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа. Энэхүү саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 44,4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Дараагийн санал Үүрийнтуяа гишүүн саналын томъёоллоо уншина.

Д.Үүрийнтуяа: 1.5 дахь хэсэгт “барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” гэснийг “импорт орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” гэж өөрчлөх.

Р.Сэддорж: Санал гаргасан Үүрийнтуяа, Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа. Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 44,4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Дараагийн санал Үүрийнтуяа гишүүн саналын томъёолол.

Д.Үүрийнтуяа: 8 дугаар хэсгийн А, Б-д байгаа төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор төсвийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг нягтлах тухай, Б-д байгаа бүтээмжид суурилсан төрийн албан хаагчийн цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох гэсэн 2 заалтыг нэгтгэх санал гаргаж байгаа. Редакцыг, нэгтгэн редакц хийх.

Р.Сэддорж: Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа. Үүрийнтуяа гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалт. 44,4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Дараагийн санал Үүрийнтуяа гишүүн саналын томъёолол уншина.

Д.Үүрийнтуяа: 8.В-д заасан үр өгөөж бага, олон нийтийн арга хэмжээ, сурталчилгаа, гадаад томилолт, автомашин, тавилга худалдан авах зэрэг урсгал

зардлыг үе шаттайгаар бодитой бууруулах гэдэг энэхүү заалт нь Төрийн хэмнэлтийн хуультай давхцаж байгаа тул энэ заалтыг хасах саналтай байна.

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүний гаргасан энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 22,2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Дараагийн санал Үүрийнтуяа гишүүн саналын томьёолол уншина.

Д.Үүрийнтуяа: 2 дугаар зүйл. 2.1 дээр өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг тогтворжуулах, эдийн засгийн бодит орлогыг хамгаалах чиглэлээр мөнгөний болон макро зохистой бодлого гэсний макро зохистой бодлогын оронд макро эдийн засгийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх гэж өөрчлөх.

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүний гаргасан энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 33,3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Дараагийн санал Үүрийнтуяа гишүүн саналын томьёолол уншина.

Д.Үүрийнтуяа: 2 дахь хэсэг дээр 8.2.2 дээр энэ гадаадын банкны салбаруудыг гээд ороод ирж байгаа юм. Тэгээд энэ нь нэг банкны хэд хэдэн салбар орж ирэх юм шиг ойлголтыг өгөөд байгаа юм. Тийм учраас олон тооны дагаврыг нь гадаадын банкнуудын салбарыг гэдэг томьёоллоор өөрчилж оруулж байна.

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүний гаргасан энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Болсон уу Үүрийнтуяа гишүүн? Сүүлийн санал, саналын томьёоллыг уншъя Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Тогтоолын төслийн 3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн явц биелэлтийг гэсэн хэсгийг энэхүү тогтоолыг шуурхай хэрэгжүүлж, биелэлтийг заалт бүрээр гарган, Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын чуулганд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Занданшатар/, Монголбанк /Наранцогт/, Санхүүгийн зохицуулах хороо /Жамбаажамц/-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо Сэддорж, Төсвийн байнгын хороо /Наранбаатар/-т тус тус даалгасугай гэж. Тэгээд энд оруулж байгаа өөрчлөлт нь болохоор зөвхөн одоо байгаа тогтоолын төсөл дээр зөвхөн тайлагнах процессыг холбогдох газруудад өгөөд байгаа юм. Тэгэхээр шуурхай хэрэгжүүлэх гэдэг чиг үүргийг нь, тайлагнах, хянах 3 процесстой нь хамтад нь оруулж үүрэг өгөх нь зүйтэй гэж үзэж дараах өөрчлөлтийг санал оруулж байгаа юм.

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүний гаргасан энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх санал хураалт явуулъя. Саналын томьёоллыг уншъя.

Чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт явуулъя дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд танилцуулна. Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

15.40 цаг

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байна, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА